



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ, ОНТХГН-НӨХӨРЛӨЛҮҮДИЙН

ТУХАЙЛСАН ЗҮЙЛ АМЬТДЫН МОНИТОРИНГ СУДАЛГААНЫ ОЙЛГОЛТУУД



ГАРЫН АВЛАГА

2016 ОН

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ,
ОНТХГН-НӨХӨРЛӨЛҮҮДИЙН

ТУХАЙЛСАН ЗҮЙЛ АМЬТДЫН МОНИТОРИНГ СУДАЛГААНЫ ОЙЛГОЛТУУД,
ГАРЫН АВЛАГА



United Nations Decade on Biodiversity

2016 ОН



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.

Энэхүү гарын авлагыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны Сангийн буцалтгүй тусламжаар Байгаль орчин, аялал жуучлалын яамтай хамтран хэрэгжүүлж буй “БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ” – МОН/13/303 төслийн хүрээнд бэлтгэн, байгаль хамгаалагч нарт зориулан хэвлүүлэв.

БОЛОВСРУУЛСАН:

Д.ЭНХБИЛЭГ

НҮБ-ын БОЯБ-ын төслийн үндэсний зөвлөх

Г.МАЙНЖАРГАЛ, (Ph.D)

ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн,
Шувуу, шавж судлалын лаборатори

ХЯНАСАН:

Б.ОЮУНТҮЛХҮҮР

Төслийн зохицуулагч

ДИЗАЙНЫГ:

Б.Сарнай

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

Хэвлэлийн хуудас 7.25

Хэвлэсэн огноо 2016-11-11

ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч, байгаль хамгаалагч та бүхэнд зориулсан биологийн олон янз байдлыг, таних, судлах, түүний тоо толгой, амьдрах орчинд хэрхэн мониторинг хийх талаарх гарын авлага номыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль хамгаалах сан (ДДБХС)-гийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн хүрээнд боловсруулсан болно. Энэхүү төслийн гол зорилго нь Монгол орны дэлхийд ховордсон биологийн төрөл зүйлийн оршин амьдах орчныг бүрдүүлэх улмаар олон төрөлт экосистемийн нэгдмэл байдлыг хангахад оршино.

Тусгай хамгаалалттай газрын хилийн гадна орших биологийн төрөл зүйл нь асар богино хугацаанд өсөн нэмэгдэж буй уур амьсгал болон нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, тогтвортой бус ургамлын гарц зэрэг дарамт бэрхшээлтэй тулгарсаар байна. Тиймээс улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс гадагш оршин амьдрах эдгээр чухал биологийн төрөл зүйлийг цогцоор нь хамгаалах, хамгаалалтын уян хатан дэглэмийг хэрэгжүүлэх, хамгаалалтад орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага урган гарч байна. Эдгээр газар нутагт тухайн байгалийн нөөцөд түшиглэн амьдарч, үйл ажиллагаа явуулж буй байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн тоо өдөр ирэх тусам нэмэгдэж, тэдгээрийн байгаль хамгаалахад оруулж буй хувь нэмэр, үүрэг, хариуцлага улам өссөөр байгаа билээ.

“Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн хүрээнд гурван орон нутгийн тусгай хамгаалалттай газар /Гулзат, Түмэнхаан-Шалз, Хавтгар/-т нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлж, хамтын менежментийн бүтэцийг загвар байдлаар үүсгэн байгуулах, тохиромжтой санхүүжилтийн механизмыг хэрэгжүүлэх, менежментэд оролцогч талуудыг чадавхжуулах, идэвхтэн байгаль хамгаалагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Энэхүү гарын авлага нь биологийн олон янз байдлын талаарх өргөн цар хүрээтэй мэдээллийг агуулахын сацуу төслөөс 2015 онд гүйцэтгэсэн **“Одоогийн тусгай хамгаалалттай газар нутгууд хоорондын уялдаа холбоог бий болгох замаар төлөөлөл нь бүрэн хамрагдаагүй экологийн бүс нутаг болох цагаан зээр, аргаль хонь, цэн тогоруу, ойн туруутан амьтны нүүдлийн болон тархац нутгийг тодорхойлох”** сэдэвт судалгааны үр дүнд түшиглэсэн бөгөөд идэвхтэн байгаль хамгаалагчид, байгаль орчны хяналтын улсын байцаагч та бүхний өдөр тутмын мониторингийн ажилдаа ашиглаж төрөлх нутгийнхаа унаган байгалийг хамгаалахад тус нэмэрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж

Гарчиг

Өмнөх үг	1	ГУЛЗАТ орон нутгийн хамгаалалттай газар	58
Төслийн тухай болон зорилт, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар товч	3	ХАВТГАР орон нутгийн хамгаалалттай газар	71
Биологийн олон янз байдал	5	ТҮМЭНХААН-ШАЛЗ орон нутгийн хамгаалалттай газар	85
ОУБХ-ны (IUCN) ангиллын тухай	14	ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:	96
БОАЖЯ, НҮБ-ын төслийн зорилтот газрууд буюу ОНТХГН-ийн байршил, зарим онцлогууд	17	БОЯБ хамгаалал, түлхүүр зүйлүүд ба холбоос нутгийн тухай ойлголт	108
ОНТХГН-т БОЯБ-ын хамгаалал, ба тухайлсан зүйлүүдийн мониторинг судалгаа	29	Ашигласан хэвлэл	120
		Зургийн эх сурвалж	123

Төслийн тухай болон зорилт, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар товч

ТӨСЛИЙН НЭР: “БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ” – МОН/13/303

Төслийн зорилго:

Монгол орны олон янз экосистемийн нэгдмэл байдлыг хангаснаар дэлхийн хэмжээнд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн оршин байх нөхцлийг бүрдүүлнэ

Төслийн зорилт:

Экосистемийн төлөөлөл нь тусгай хамгаалалтанд бүрэн хамрагдаагүй газруудад нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутаг (НИХГН) -уудыг бий болгох замаар улсын Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) -ийн сүлжээг өргөжүүлэх явцыг эрчимжүүлнэ.

Хэрэгжүүлэгч:

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)

Санхүүжүүлэгч:

Даян Дэлхийн Байгаль Орчны Сан	1,300,000 ам доллар
НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр	200,000 ам доллар
БОАЖЯ	500,000 ам доллар

Нийт төсөв:

1,5 сая ам доллар

Хэрэгжих хугацаа:

2013 – 2018 он /5 жил/

Төсөл хэрэгжих газар:

- “Гулзат” ОНТХГ (Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумд) – 215.9 мян. га
- “Хавтгар” ОНТХГ (Хэнтийн аймгийн Батширээт сум) – 104.9 мян.га
- “Түмэнхаан-Шалз” ОНТХГ (Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Хэнтий аймгийн Норовлин сум) – 374.3 мян. га

ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН:

Үр дүн 1. Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээг өргөжүүлэх зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бий болгох

- Нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгийн сүлжээг байгуулах, сүлжээнд хамрагдах газруудын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, тэдгээрийн хамгаалалтын менежментийг үр ашигтай хэрэгжүүлэх талаар ТХГН -ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох дүрэм журмыг гаргах;
- Нэмэлт өөрчлөлт оруулсан хууль, журмын хүрээнд улсын ТХГН -ийн сүлжээнд олон тооны НИХГН хуулийн дагуу зөвшөөрөгдсөн байна.

Үр дүн 2. Нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгийн менежментийн тогтвортой байдлыг хангах бүтцийг буй болгон чадавхижуулах, бэхжүүлэх

- Нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаж буй газруудыг бүртгэж албажуулсан байна;
- Төсөл хэрэгжиж буй 3 ОНТХГ-ыг өргөжүүлэн тэлэх, хамгаалалтын менежментийг хангах бүтэц зохион байгуулалт, эрх зүйн орчин бүрдсэн байна;
- Төслийн хүрээнд гарсан тэргүүн туршлагуудыг баримтжуулан, нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгийн менежментийг үр ашигтай явуулах зорилгоор үндэсний хэмжээнд сурталчилан түгээх



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ (БОЯБ)

Байгаль хамгааллын судлагдахууны нэг чухал хэсэг биологийн олон янз байдал юм.

Биологийн олон янз байдал (Bio-Diversity) гэдэг нэр томъёо цүнзгий агуулгатай, нийлмэл ойлголт юм.



Convention on
Biological Diversity

Байгаль хамгааллын үндсэн асуудлын нэг...

Энэ ойлголтонд зөвхөн биологийн төрөл, зүйлийн олон хэлбэрийн тухай ангилал зүйн шинжтэй утга биш, харин бидний амьдарч байгаа орон гэр болсон сав ертөнц түүний үл давтагдах мөн чанар болох амьдралын олон хэлбэр, түүний бүтэц, үйл ажиллагааны тухай агуулга хадгалагдана.

Биологийн олон янз байдлын конвенцийн хоёрдугаар зүйлд энэ нэр томъёог: "янз бүрийн гарал үүсэл бүхий амьд организмын хувьсал өөрчлөлт, ... түүнийг агуулж байгаа экологийн иж бүрдэл;

түүний илрэл болох зүйлийн доторх генетик олон янз байдал, зүйлийн олон янз байдал, экосистемийн олон янз байдлыг хамаарна" гэжээ.

Биологийн олон янз байдал хэмээх ойлголтыг зохион байгуулалтын гурван өөр төвшинд авч үзнэ. Энэ нь ургамал, амьтны бүх зэрлэг зүйл, үүлдэр, сортын доторх **Генийн олон янз байдал; Амьдсын буюу төрөл, зүйлийн олон янз байдал; Экосистемийн олон янз байдал** гэсэн гурван өөр төвшин юм.



Биологийн олон янз байдлын конвенци



Биологийн олон янз байдлын конвенцийн үндсэн үзэл санаа хоёр үндсэн зорилгод, тухайлбал:


а) Биологийн олон янз хэлбэрийг түүний анхдагч амьдрах орчинд нь хамгаалах,

б) Зүйл, экосистем, түүний нөөцийн ашиглалтын тогтвортой (sustainability) байдлыг хангахад чиглэнэ.

Энэ гэрээнд нэгдсэн улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээрх биологийн олон янз байдлаа бүртгэх, түүнчлэн доройтсон амьдрах орчныг

ургамал, амьтны аймаг, түүний генетик олон янз байдлын хамт хадгалан хамгаалах үүрэг хүлээдэг. Түүнчлэн амьдрах орчны гадуурх хамгаалалтын арга хэмжээ буюу байнгын хяналт (мониторинг), байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, судалгааг эрчимжүүлэх, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, технологи дамжуулах үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.

Биологийн олон янз байдал бол мөн чанартаа хүрээлэн буй орчны нөхцөлийн орон зайн болон цаг хугацааны өөрчлөлтөнд биологийн системийн эргэлт буцалтгүй зохилдолгооны үр дүн хэмээн үзсэн байдаг. Ингэснээр биологийн олон янз байдал нь нэг талаас өөрийн **бүтэц байгуулалт**, хоорондын уялдаа холбооны нийлмэл байдлаараа бүтцийн болон үйл ажиллагааны, нөгөө талаас орчны янз бүрийн нөхцөл, орон зай цаг хугацааны тасралтгүй мөчлөгт биологийн системийн зохицох чадварыг илэрхийлэх динамик-хөдөлгөөнт хандлагатай юм.





Генетик олон янз байдал

Амьд биетийн нэгэн үндсэн шинж бол түүний үй олон хэлбэр юм. Нэг зүйлд хамаарах бодгаль бие бүхэн өөр хоорондоо ялгагдах генетик онцлогтой. Удамшлын мэдээллийг агуулагч нь тогтмол бүтэцтэй боловч үй олон шинэ хувилбар бүтээх гайхамшигт чадвартай.

Аварга том халим, аль эсвэл өчүүхэн жижиг бактери байлаа ч ялгаагүй амьдралын мөн чанарыг тодорхойлох үндсэн шинж болох амьд биеийн үйл ажиллагаа хэвийн явагдахад нь олон тооны удирдамж (ген) хэрэгтэй болох бөгөөд тэр нь ДНХ-ийн молекулд кодлогдон агуулагдана. Энэхүү зааварчилгаа янз бүрийн хүчний үйлчлэлээр (физик, хими, биологи) өөрчлөгдөх боломжтой бөгөөд үүний үр дүнд гарсан өөрчлөлтийг мутаци гэнэ. Мутаци үүсэх нь шинжлэх ухааны одоогийн мэдлэгийн төвшинд ойлгож байгаагаар тохиолдлын үйл явц бөгөөд **генетик олон янз байдал** бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.

Аливаа нэг шинж тэмдэг (ген) байгалийн популяцид цорын ганц тогтвортой хэлбэрээр тохиолдох нь ховор, харин янз бүрийн давтамжаар, янз бүрийн хувилбар үүсэн илэрнэ.

Генетик олон янз байдал өөрийн өвөрмөц онцлогтой. Нэг зүйл харилцан адилгүй хэмжээтэй хэд хэдэн популяциас тогтож байгаа бол орон зайн хувьд тусгаарлагдсан популяци нь өөр хоорондоо ялгаатай **генетик олон янз байдлыг** бий болгоно. Нэг зүйлийн доторх генийн олон янз байдал нь орчны тодорхой нөхцөлд илүү зохицсон шинжийг сонгон ашиглах нөөцийг бүрдүүлнэ. Тухайлбал: таримал ургамлын олон сортыг гарган авсан зүйлүүд байгаль дээрээ зэрлэг хэлбэрээр өнөөг хүртэл зэрэгцэн оршсоор байна.


Зүйлийн олон янз байдал

Биологийн олон янз байдлын дотроос хамгийн ойгомжтой бөгөөд байгаль хамгааллын практикт түгээмэл хэрэглэгдэх нь зүйлийн олон янз байдал юм.


Аливаа газар нутгийн байгаль хамгааллын үнэ цэнийг тодорхойлоход юуны өмнө зүйлийн олон янз байдал, түүний бүрдлийг авч үзнэ. Зүйлийн баялаг дэлхийн өнцөг булан бүрт харилцан адилгүй зүй тогтоор тархана. Зүйлийн баялаг дэлхийн бөмбөрцөгийн халуун бүсэд хамгийн их байх бөгөөд хойд, өмнөд туйл руу шилжих тутам ядмаг болно. Нөгөө талаар халуун бүсийн зүйл харьцангуй бага талбайд

тархдаг бол сэрүүн бүсийн зүйл илүү өргөн нутаг хамарсан тархалттай байна. Тиймээс аливаа нутаг дэвсгэрт байгаа зүйлийн нийт бүрдэл биш, харин байгаль хамгааллын үндсэн зорилгын үүднээс харьцуулж болох үзүүлэлт чухал үүрэгтэй. Ийм үзүүлэлт бол тухайн амьдрах орчны хэв шинжийг тодорхойлогч зүйлийн (эндемик зүйл) бүрдэл юм. Нөгөө нэг анхаарах зүйл бол хаана ч гэсэн байгалийн аясаараа байгаа амьдрах орчинд байх зүйлийн тоо хүний үйл ажиллагааны улмаас өөрчлөгдөж анхдагч хэв шинжээ алдсан амьдрах орчинд байх зүйлийн тооноос хавьгүй их байна. Хээрийн экосистемийн байгаль хамгааллын үнэ цэнийг тодорхойлоход нийт зүйлийн тоо ядмаг байх нь асуудлын гол биш, харин жинхэнэ хээрийн хэв шинжийг тодорхойлогч ургамал, амьтны төлөөлөл байгаа эсэх нь шийдвэрлэх үүрэгтэй байна.

Манай орны хувьд дээд ургамал, сээр нуруутан амьтны - зүйлийн бүрдэл ерөнхийдөө мэдэгдэх болсон ч тодорхой нэг газар нутгийг сонгон авч үзвэл ургамал, амьтны зүйлийн баялаг, байршил, тоо хэмжээний талаарх мэдлэг өнөөг хүртэл хангалтгүй хэвээр байна.



Монгол орны шувууны зүйлийн баялгийн давхцааны шинжилгээ. Монгол улсын Шувууны Улаан данс (2011)






• Монгол орны шувууны зүйлийн баялгийн давхцааны шинжилгээ;

• Монгол орны шувууны “Ховордож байгаа” зүйлүүдийн давхцааны шинжилгээ;

• Монгол орны шувууны “Ховордож болзошгүй” зүйлүүдийн давхцааны шинжилгээ;

• Монгол орны шувууны “Эмзэг” зүйлүүдийн давхцааны шинжилгээ;



Амьдрах орчны олон янз байдал


Зүйлийн олон янз байдлыг тодорхойлох үндсэн нөхцөл бол амьдрах орчны олон янз байдал юм.

Амьдрах орчны олон янз байдлыг тодорхойлох хамгийн энгийн нэгж нь биотоп, түүний сүлжээ юм.

Ургамал, амьтны ихэнх зүйл зөвхөн нэг төрлийн биотопыг сонгон амьдрах нь тун ховор. Амьтад жилийн турш олон янзын амьдрах орчныг сонгон байршихын зэрэгцээ, жилийн нэг улиралд, аль эсвэл нэг өдөрт ч гэсэн олон янзын биотоп дамжин шилжих, бэлчээрлэх шаардлага гарна.

Энэ нь амьтдын орон зайн шаардлага, шилжилт хийх чадвараас ихээхэн хамаарна. Нөгөө талаар амьтдын амьдрах орчны сонголт нь хөгжлийн үе шат (шувуудын үүрлэх, хоёр нутагтны үржилд орох орчин г.м), амьдралын хэвийн үйл ажиллагааны олон хэлбэрээс (хооллох, хорогдох, амрах, өвөлжих г.м) хамаарч өөр өөр байна.

Хаана нэг төрлийн амьдрах орчин их хэмжээний талбайг эзлэн оршино тэнд амьдралын харьцангуй нэг төрлийн хам бүрдэл (биоценоз) илэрнэ. Амьдрах орчны ландшафт-экологийн үндсэн шинжийг тодорхойлж, түүний бүртгэл, зураг үйлдэх нь зөвхөн газар зохион байгуулалтын талаасаа биш, харин хаана, ямар орчинд ямар ургамал ургадаг, ямар амьтан амьдардаг болохыг нэгд нэгэнгүй мэдэх боломжийг олгох, тухайн нутгийн өвөрмөц онцлогт тохируулан аж ахуйн ямар хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэх нь экологийн хувьд зохистой (ландшафтын экологи), үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх экологийн үндэслэлийг (экологи-эдийн засгийн үнэлгээний хүрээнд) зөв тооцоолох боломж олдоно.





Тухайлсан зүйлийн талаарх ойлголт

БОЯБ-ын дотроос байгаль хамгаалах арга хэмжээнд илүү анхаарал татах онцлог зүйл, ангилалзүйн бүлгийг сонгон хэрэглэх арга байдаг. Үүний дотор байгаль хамгааллын **индикатор** буюу **тодорхойлогч** зүйлийн тухай ойлголтыг авч үздэг байна. Тодорхойлогч зүйлийг а/ хүний үйл ажиллагааны нөлөөллийг үнэлэх, б/ бусад зүйлийн популяцийн хандлагыг хянах, в/биологийн олон янз байдлын баялаг нутгийн байршлыг бүс нутгийн хэмжээнд илрүүлэхэд хэрэглэдэг.

Экосистемийн амьдралд чухал үүрэгтэй зүйлийг байгаль хамгааллын практикт нөмөр буюу шүхэр зүйл (*Umbrella species*), анхаарал татах туг зүйл (*Flagship species & Charismatic species*), түлхүүр зүйл (*Keystone species*), орчны индикатор-тодорхойлогч зүйл хэмээн ялгаж, тухайлан ялгана.

ШҮХЭР ЗҮЙЛ: Амьдрах чадвартай популяци нь байгалийн эвдрээгүй анхдагч тогтолцоонд их хэмжээний талбай эзлэн оршдог зүйл амьтан. Ийм зүйлийг хамгаалах үйл ажиллагааны нөмөр нөөлөгт бусад олон зүйл, тогтолцоог хамгаалах боломжтой юм. Ийм зүйлийн жишээнд говийн нөхцөлд хавтгай тэмээ (*Camelus ferus*), тайгад хүрэн баавгай (*Ursus arctos*) зэргийг тооцож болно.

АНХААРАЛ ТАТАХ ЗҮЙЛ: Олон нийтэд танил бөгөөд анхааралд амар хялбар өртөх, дэмжлэг авах боломжтой зүйл амьтан. Ийм зүйлийг ашиглан байгаль хамгаалах үйл ажиллагааг явуулснаар бусад олон зүйлийг хамгаалах зорилтыг зэрэг хэрэгжүүлж болно. Ийм зүйлийн жишээнд манай орны хувьд цоохор ирвэсийг (*Uncia uncia*) авч үзэж болно.



Тухайлсан зүйлийн талаарх ойлголт

ТҮЛХҮҮР ЗҮЙЛ: Экосистемийн нийлмэл тогтолцооны чухал байр суурь эзэлдэг зүйл амьтан. Түүнээс олон зүйлийн тархалт, байршил, хам амьдралын хэвийн ажиллагаа хамаатай байдаг. Байгаль хамгаалал, ялангуяа тодорхой экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад анхаарч үзүүштэй зүйлийн нэг юм. Манай орны хээрийн бүсэд цайвар үлийч (үлийн цагаан оготно) түлхүүр зүйлийн үүрэг гүйцэтгэнэ.

ИНДИКАТОР буюу ТОДОРХОЙЛОГЧ ЗҮЙЛ:

Тодорхойлогч зүйлийг дотор нь а/ биологийн олон янз байдлын, б/ хүрээлэн буй орчны өөрчлөлтийн тодорхойлогч хэмжээн ялгаж үзнэ. Хүрээлэн буй орчны өөрчлөлтийн тодорхойлогч нь:

- **Эрүүл ахуйн тодорхойлогч зүйл** (тухайлбал, ямар нэг төрлийн бохирдолд мэдрэмтгий зүйл)
- **Менежментийн тодорхойлогч зүйл** (тоншуул шувуу ойн төлөв байдлыг илтгэх тодорхойлогч болно)
- **Популяцийн тодорхойлогч зүйл** (бусад зүйлийн популяцийн хандлагыг илэрхийлэгч зүйл)

Европын нөхцөлд биотопын сүлжээ болон **зорилтот зүйлийн** үзэл баримтлалыг илүүтэй үздэг. Амьдрах орчин нь олон жижиг хэсэгт хуваагдсанаас нэг бол бие даасан биотоп, аль эсвэл зүйл амьтан бүрийг дангаар нь хамгаалах хандлага бэрхшээлтэй тул тухайн бүс нутагт анхаарал татах гол биотоп эсвэл хамгааллын үнэ цэнэ ихтэй, ангилал зүй болон амьдралын төрхөөрөө ялгаатай олон зүйлийг жагсаан (зорилтот зүйл **target species**) тэдгээрийг иж бүрнээр хамгаалдаг.


Түлхүүр зүйлүүдийн хамгааллын статус



Засгийн 2001 оны 164-р болон 2012 оны 7-р тогтоолоор “Ховор амьтны жагсаалт”-д бүртгэгдсэн зүйл амьтан



Монгол улсын “УЛААН НОМ” (1987, 1997, 2013 он) нэн ховор болон ховор зэрэглэлд бүртгэгдсэн зүйл амьтан



Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN-ОУБХХ) Улаан дансны шалгуураар ховордлын зэрэг нь үнэлэгдсэн зүйл амьтан


Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийн (CMS) I болон II хавсралтанд бүртгэгдсэн зүйл амьтан

Азийн Улаан номонд бүртгэгдсэн зүйл шувуу

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) I болон II хавсралтанд бүртгэгдсэн зүйл амьтан



Тусгай (трофи) агнуурын зүйл амьтан



ОУБХ-ны (IUCN) ангиллын тухай



УСТСАН (EX) Extinct

Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг **Устсан** гэсэн ангиллаар үнэлдэг. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд, тухайн зүйлийн

өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг Устсан гэсэн ангилд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.

БАЙГАЛЬД УСТСАН (EW) Extinct in the Wild

Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа, эсвэл тухайн зүйлийн популяцийг (популяциудыг) түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байлгаж байгаа бол Байгальд устсан гэсэн ангилалд оруулдаг. Тухайн ангилал зүйн нэгжийн бодгаль байж болох амьдрах орчин тохиромжтой

цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд Байгальд устсан гэсэн ангилд оруулна. Судалгааг тухайн зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.

БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УСТСАН (RE) Regionally extinct

Тухайн ангилал зүйн нэгжийн хамгийн сүүлийн бодгаль үхсэн, эсвэл үзэгдэхээ байсан бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн ангилалд оруулдаг. Бүс нутгийн хэмжээнд устсан

гэсэн ангилалд тухайн зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.

УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) Endangered

Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж байгаа гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд

устах эрсдэл туйлын их байгааг илтгэн Устаж байгаа гэсэн ангилалд хамааруулна.

<p>УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) Endangered</p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас E хүртэлх аль нэг шалгуураар Устаж болзошгүй гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол</p>	<p>байгальд устах эрсдэл маш их байгааг илтгэн Устаж болзошгүй гэсэн ангилалд хамааруулна.</p>
<p>ЭЭМЗЭГ (VU) Vulnerable</p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас E хүртэлх аль нэг шалгуураар Эмзэг гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах</p>	<p>эрсдэл их байгааг илтгэн Эмзэг гэсэн ангилалд хамааруулна.</p>
<p>ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT) Near threatened</p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийг А-гаас E хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ангиллаар үнэлэх боломжгүй боловч ойрын ирээдүйд устаж,</p>	<p>ховордож байгааг илтгэсэн дээрх ангиллын аль нэг рүү шилжин орж болзошгүй зүйлийг Ховордож болзошгүй гэсэн ангилалд хамааруулна.</p>
<p>АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC) Least concerned</p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийг А-гаас E хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг ангиллын аль нэгээр үнэлэх боломжгүй</p>	<p>байгаа тул Анхааралд өртөхөөргүй зүйл гэсэн ангилалд хамааруулна. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ ангилалд хамаарна.</p>
<p>МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD) Data deficient</p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн популяцийн төлөв байдал болон тархацыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй байгаа нөхцөлд Мэдээлэл дутмаг гэсэн ангилалд хамааруулна. Тухайн зүйлийн элбэгшил, тархацын талаар мэдээлэл дутмаг байж болно. Мэдээлэл дутмаг гэсэн ангилал нь устах, ховордох эрсдэлийг илэрхийлсэн ангилал биш юм. Зүйлийг энэ ангилалд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээлэл хэрэгтэй байгааг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийгдэж,</p>	<p>тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой байж болно. Байгаа мэдээллийг ашигтайгаар хэрэглэх нь чухал байдаг. Тухайн зүйлийг Мэдээлэл дутмаг мөн устах эрсдэлтэйг илэрхийлсэн ангиллын алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрэв тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрсдэлтэй ангилалд оруулах нь зайлшгүй зөв зүйтэй шийдвэр юм.</p>
<p>ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NA) Not applicable</p>	<p>Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг Үнэлэх боломжгүй гэсэн ангилалд хамааруулна.</p>	

ОНТХГН-ийн БОЯБ-ын хамгаалалд нөхөрлөлүүдийн оролцоо, мониторинг судалгаа чухал



БОАЖЯ, НҮБ-ын төслийн зорилтот газрууд буюу ОНТХГН-ийн байршил, зарим онцлогууд

Түмэнхаан-Шалз болон Хавтар ОНТХГН байршил нь бүс нутаг ландшафтын хувьд манай орны Хангай-Хэнтийн уулархаг их муж болон Төв азийн өндөрлөг, тал хотгор, уулт их мужийн завсрын нутаг болсноороо дээрх хоёр бүсийн биологийн төрөл зүйлүүд, тухайлбал том хөхтөн амьтад буюу ой, ойт хээрийн болон тал хээрийн туруутан амьтдын хоршил, нийлмэл байдлын төлөөлөгчид болох халиун буяа, бор гөрөөс, зэрлэг гахай, цагаан зээрийн популяцийн хамгаалалд үүрэг оролцоотой болохын зэрэгцээ зүүн талаасаа Их хянганы уулархаг мужийн төлөөлүүдийн оролцоотой амьтны аймгийн өвөрмөц бүрэлдэхүүн, онцлогтой болж байна.

Ялангуяа энэ зорилтот ОНТХГН-ууд манай орны тал хээрийн унаган туруутан цагаан зээрийн тархац, популяцийн баруун хойт хэсгийн хамгаалалд чухал үүрэгтэй.

Дэлхийн экологийн бүс нутгийн хувьд Монгол манжуурын хээр, Дагуурын ойт хээрийн бүсэд хамрагдаж, манай орны Онон, Улз голын сав мөн Хэрлэн голын савын дунд оршиж байгаа нь дэлхийн өндөглөн зусдаг нүүдлийн болон усны шувуудын элбэг буюу биоценозид чухал үүрэгтэй зүйлүүд болон ховор ховордсон тогоруу, галууны


төрлийн шувуудын хамгийн чухал үржиж, төлжин популяцийн сэргэн нөхөлтөнд чухал үүрэг гүйцэтгэдэг ус намгархаг газрын хамгааллын төв цэг Шувуудад чухал (Bird Important area) болдгоороо ихээхэн онцлог юм. Ялангуяа ургамлын тойргийн хувьд Монгол дагуурын ойт хээр болон Дундад халхын хээрийн завсарын нутаг тул зүйлийн баялгийн хувьд өвөрмөц, түүнийг дагасан шавж, сээр нуруугүйтний ангийн баялаг зүйлүүд биомассыг бий болгож, тэдгээрээр хооллодог шавж, жигүүртэн, хөхтний

экологийн хувьд дан болон хоршмол бүлгэмдэлтэй байгаа нь үндэслэлтэй байна.


Байгалийн бүс бүслүүрийн хувьд хээрийн бүсэд хуурай хээрийн бүс нэвтрэн орж, нугат хээртэй хиллэж буй байдал нь аливаа байгалийн өөрчлөлтөнд эмзэг биш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн байж болзшгүй байдал нь зарим хөхтөн, тухайлбал цагаан зээрийн голомт нутаг, популяцийн цөм нутаг тогтвортой байх мөн дагуурын хээрийг дагаж бусад харь зүйлүүд нэвтрэх таатай

нөхцөлийг бүрдүүлснээрээ биологийн олон янз байдлын хувьд шилжмэл, хувирамтгай байх нөхцөлийг бүрдүүлж байна. Манай орны ойн тархалтын зүүн өмнөт зах, Сибирийн тайгын мөн өмнөт хязгаар, Их хянганы нурууны баруун үзүүрийн хэсэг болж ой, ойт хээр болон хээрийн дундын нутаг тул ойн туруутан халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, тал хээрийн туруутан цагаан зээрийн тархац нутгийн хилийн давхцал тул хамгааллын менежментийн хувьд онцгой анхаарал хандуулж судлах шаардлагтайг тодруулж, зөвлөж байна.


Гулзат ОНТХГ-ын хувьд Монгол орны баруун хойт хэсэг Алтай соёны бүс нутагт оршдогоороо өндөр уулын бүсийн экосистем, амьдтын зүйлийн бүрдэлтэй төдийгүй манай орны төдийгүй дэлхийд ховордсон, уламжлалт болон олон улсын трофей агнуурын гол амьтан аргаль хонин байрших үндсэн таатай нутгийн нэг болно. Үүнээс гадна янгир ямаа, алтайн хойлог, монгол тарвага, цоохор ирвэс зэрэг алтайн уулсын үндсэн амьтад тархахаас гадна зэрлэг гахай, халиун буга зэрэг ойн туруутнууд байршдаг өвөрмөц нутаг юм.




ОНТХГН-н байршил ба УТХГН түүний орчны бүс




ОНТХГН ба Монгол орны байгалийн бүс бүслүүр




ОНТХГН ба Монгол орны ландшафт




ОНТХГН ба Монгол орны ургамлын тойрог




ОНТХГН ба Монгол орны экологийн бүс нутаг



ОНТХГН ба Монгол орны хуурайшлын индекс




ОНТХГН ба Монгол орны цөлжилтийн зэрэглэл




ОНТХГН ба Монгол орны малын нягтшил


(хонин толгойгоор, 2010 он)



ОНТХГН ба Монгол орны цөлжилтийн зэрэглэл: цөлийн бүсийн өөрчлөлтийн таамаглал



ОНТХГН ба Монгол орны шувуудад чухал газрууд



ОНТХГН-Т БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН
ХАМГААЛАЛ БА ТУХАЙЛСАН ЗҮЙЛҮҮДИЙН
МОНИТОРИНГ СУДАЛГАА



ОНТХГН ба нөхөрлөлүүдийн БОЯБ-ын мониторинг судалгаа

*Урт удаан хугацааны
туришид байнга тодорхой
давтамжтай үйцэтгэдэг
ажиглалт судалгаа
Мониторинг гэдэг.*


Мониторинг судалгааг зөвхөн байгаль хүрээлээн буй орчин, ан амьтны судалгаанд хэрэглэдэг гэсэн ойлголт биш бөгөөд шинжлэх ухаан, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт өргөн хүрээнд ашиглахдаа улам боловсронгуй болгож хавсран хэрэглэдэг.

Аливаа экосистем түүний иж бүрдэл, биологийн төрөл зүйлүүдийн шинж чанар,

утга учир, зүй тогтоц, түүний нэгдмэл байдлыг хадгалах, хамгаалах, сэргээхэд шаардлагатай, баталгаатай, мэдээлэл цуглуулах, судлан шинжлэх, түүний цаашдын байдал, хэтийн төлөвт зөв, бодитой дүгнэлт шинжилгээ хийхэд мониторинг судалгааны үүрэг ач холбогдол оршино.



Мониторинг судалгааны үндсэн зарчим



*Мониторинг судалгааг
үндсэн хоёр зарчимд
хуваан үздэг.*

1. Орон нутгийн ард иргэдэд түшиглэсэн мониторинг судалгаа.

Энэ нь **"нутгийн иргэдээс асуу"** гэсэн үндсэн зарчимтай ба нутгийн иргэдээс тодорхой төлөвлөгөө, нөхцөлөөр дэмжлэг туслалцаа авч, хамтран ажиллах аргыг хэлдэг бөгөөд үүнийг биологичид, судлаачид тэр бүр хүрч очих боломжгүй өргөн уудам нутаг хамарсан УТХГН түүний орчмын бүсэд хэрэглэж болдог.


2. Шууд ажиглалтанд тулгуурласан мониторинг судалгаа

Үүнийг судлаачид гүйцэтгэдэг ба энэ арга нь:

- Төлөвлөгөөтэй давтамжтай хээрийн (газрын) судалгаа
- Агаарын тандан судалгаа
- Радио телеметрийн болон хиймэл дагуулд үндэслэгдсэн зайнаас тандан судалгаа гэсэн хэдэн үндсэн аргуудыг өөртөө хамруулах бөгөөд мэргэжлийн судлаачид **"өөрөө хий"** гэдэг үндсэн зарчимд тулгуурласан байна.



Мониторинг судалгааны түлхүүр зарчим



- **Давтамж:** Жилд, улиралд, сар бүр эсвэл долоо хоног бүр нэг удаа тодорхой ижил цагт эхэлж дуусгана.
- **Арга зүй:** Тухайн бүс нутаг нутагт ашиглахуйц, мэдээллийг харилцан солилцох боломжтой, энгийн хэрэглэхэд хялбар, эсвэл шинжлэх ухааны салбарын байгууллагаар хэлэлцэгдэж батлагдсан, нийтээр хүлээн зөвшөөрсөн судалгааны хуудас, тооллого, бүртгэлийн хуудас баримтыг ашиглана.
- **Талбай, байршил нутаг:** Хэлэлцэж тохирсон эсвэл санаандгүй байдлаар дээж талбайнуудыг сонгож, тэндээ тогтсон байнгын судалгааны замлалуудаар гүйцэтгэнэ.

Яагаад судалгааны арга зүй ач холбогдолтой байдаг вэ?

Тухайн салбарын шинжлэх ухаанд нийтээр хэрэглэдэг, хүлээн зөвшөөрч, шалгагдаж батлагдсан арга барилыг судалгааны арга зүй гэдэг.

- Дахин давтагдах
- Харьцуулах
- Нотлох
- Дүгнэх боломжоор хангахад оршино.

Арга зүйн дагуу гүйцэтгэсэн судалгааны үр дүнг тухайн зүйл амьтны цаашдын хамгааллын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд ашиглана. Тухайлбал:

1. **Хамгаалах** (тархац хумигдаж тоо толгой цөөрвөл)
2. **Хянах** (тоо толгой өсч олширч эхэлбэл хязгаарлах)
3. **Тогтвортой ашиглах** (тоо толгой, нөөц хэвийн хэмжээнд хүрвэл тогтвортой ашиглах)

Мониторинг судалгаанд дээж судалгааны аргыг хэрэглэх

Тухайн бүс нутагтаа эсвэл хариуцан хамгаалж буй нутгийнхаа нийт талбайг бүрэн хэмжээгээр хамарч чадах боломжоор хомс байдаг тул төлөөлж, илэрхийлж чадах тодорхой газрыг дээжлэн авч судалдаг. Судлаачид үүнийг мэргэжлийн түвшинд сорилын талбай гэж нэрлэдэг. Ийм тохиолдолд:

1. **Санаандгүй**
2. **Санаатай буюу зорилготой** дээж талбайг сонгодог.

Мониторинг судалгааг гүйцэтгэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд байдаг. Үүнд:

- Хурдавчилсан
- Мэдрэмж дээр тулгуурласан
- Сайн дурын
- Хэтрүүлсэн



Судалгааны техник хэрэгсэл



- ГАЗРЫН ЗУРАГ
- МЭДЭЭНИЙ ХУУДАС
- ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР
- ШУГАМ, ТУУЗАН МЕТР
- ДУРАН, ФОТО АППАРАТ
- ДЭЭЖНИЙ УУТ: ЦААСАН БОЛОН ГЯЛГАР УУТ
- ЭМНЭЛГИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖИЙН САН
- БАЙРШИЛ ТОДОРХОЙЛОГЧ GPS БАГАЖ

Мэдээний хуудсанд:

- Он сар өдөр
- Цаг минут
- Цаг агаарын байдал
- Үзсэн амьтан
- Тэмдэглэсэн газрын солбицол/байршил, д.д.
- Нийт тоо толгой үүнээс:
 - Эр амьтан
 - Эм амьтан
 - Залуу залуу
 - Төл

Судалгаанд ашиглагдах шаардлагатай багаж, хэрэгсэл

Фото аппарат



Дуран



Байршил тодорхойлогч GPS багаж




Судалгааны мэдээ цуглуулах

ШУУД ТООЛОХ АРГА:

- **Шугаман** замналын арга (трансект)
- **Зурвас** замналын арга
- **Цэгэн** тооллого
- **Талбайн** тооллого буюу торлолын

ШУУД БУС ТООЛОХ АРГА

- Ялгадас тоолох
- Үүр ноохой, үлийгээр
- Дуудаж толлох
- Мөрөөр тоолох
- Хавхаар тоолох (мэрэгчид)






Мониторинг судалгааны үед гарч болзошгүй алдаа


- Техник хэрэгсэлийн (луужин, GPS, аппарат, дуран) алдаа
- Цаг агаарын (бороо, манан, цас) хүндрэлүүд
- Хувь хүний мэдлэг, туршлага бага
- Тухайн нутгийн онцлог орчин нөхцөлийг мэдэхгүй
- Тухайн амьтны амьдарлын онцлогийг (идэшлэх хугацаа, зан төрх) судалж мэдээгүй г.м




Мониторинг замлалд амьтныг ажиглан бүртгэх








Амьтдыг шууд бус аргаар үл мөрөөр таньж тоолох




Төрөл зүйлийн мониторингийн үед амьтныг ажиглах, тэмдэглэх, бүртгэх зарим арга:




Төрөл зүйлийн мониторинг үед амьтныг ажиглах, тэмдэглэх, бүртгэх зарим арга:



УРГАМАЛ АЖИГЛАХ, ТЭМДЭГЛЭХ, БҮРТГЭХ ЦУГЛУУЛАХ АРГА: Амьтны идэш тэжээл




ШАВЖ АЖИГЛАХ, ТЭМДЭГЛЭХ, БҮРТГЭХ ЦУГЛУУЛАХ АРГА: Амьтны идэш тэжээл



Түлхүүр зүйлүүд ба ОНТХГН суурь судалгаа

”Одоогийн тусгай хамгаалалттай газар нутгууд хоорондын уялдаа холбоог бий болох замаар төлөөлөл нь бүрэн хамрагдаагүй экологийн бүс нутаг болох цагаан зээр, аргаль хонь, цэн тогоруу, ойн туруутан амьтны нүүдлийн болон тархац нутгийг тодорхойлох” судалгааны хүрээнд



Монгол орны хэмжээнд ойн туруутан халиун буга, бор гөрөөс, баданга хүдэр, шивэр хандгай, буган цаа болон зэрлэг гахай (*Cervus elaphus*, *Capreolus pygargus*, *Moschus moschyferus*, *Alces alces*, *Rangifer tarandus*, *Sus scrofa*), тал хээрийн туруутан цагаан зээр (*Procapra gutturosa*), уулын туруутан аргаль хонь (*Ovis ammon*) болон цэн тогорууны (*Grus vipio*) түүхэн болон сүүлийн үеийн судалгааны мэдээ хэрэглэхүүнд суурилж экологийн нишийн дэвшилтэд Максент арга зүй ашиглан, уур амьсгал болон хүрээлэн буй орчны суурь 50 орчим давхарга мэдээлэлд үндэслэн боломжит амьдрах орчин, тархац нутгийг загварчлав.



Мөн судалгаанд хамрагдсан 9 зүйл амьтны тархац нутгийн давхцал бүхий чухал нутгийг тодруулах **“HotSpot Analysis”** шинжилгээг хийв.

Зүйлүүдийн тархац нутгийг монгол орны ТХГН-н сүлжээ, орон нутгийн хамгаалалттай газрууд, уул уурхайн ашиглалт хайгуулын талбай, малчдын дөрвөн улирлын байршил нутгуудтай хэрхэн давхцуулж нөлөөллийн зарим хэлбэрээр тоймлосны зэрэгцээ зарим туруутны болзошгүй нүүдлийн замыг тодруулж хамгааллын өнөөгийн болон цаашдын төлөвийг тодруулж дүгнэлт гаргав.

СУУРЬ СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН: Судалгааны дүнд монгол орны

МОЛЦОГ ХАНДГАЙ

нийт 106714 км² нутагт байрших боломжтойгоос тархац нутгийн 68% ТХГН-т, 2% лицензийн, голомт нутгийн 89.9% ТХГН-т, 1% лицензийн талбайд,

ХАЛИУН БУГА

нийт 381382 км² нутагт байрших бөгөөд тархац нутгийн 32.2% ТХГН-т, 3.1% лицензийн, голомт нутгийн 48.8% ТХГН-т, 1.5% нь лицензийн талбайд,

БАДАНГА ХҮДЭР


нийт 154475 км² нутагт байршихаас тархац нутгийн 46.3% ТХГН-т, 2.3% лицензийн, голомт нутгийн 58.2% ТХГН-т, 1.6% лицензийн талбайд,

БОР ГӨРӨӨС

нийт 393447 км² нутагт байршихаас тархац нутгийн 26.8% ТХГН-т, 3% лицензийн, голомт нутгийн 45.7% ТХГН-т, 2% лицензийн талбайд,

БУГАН ЦАА

Манай орны хойт хэсэг Хөвсгөлийн 12930 км² нутагт байрших боломжтойг тодруулав.



ЗЭРЛЭГ ГАХАЙ

нийт 312811 км² нутагт байршихаас тархац нутгийн 41.6% ТХГН-т, 3% лицензийн, голомт нутгийн 71.6% ТХГН-т, 2.3% лицензийн талбайд,

ЦАГААН ЗЭЭР

нийт 426951 км² нутагт байршихаас тархац нутгийн 11.6% ТХГН-т, 9% лицензийн, голомт нутгийн 13.8% ТХГН-т, 7.3% лицензийн талбайд,

АРГАЛЬ ХОНЬ

нийт 328453 км² нутагт байршихаас тархац нутгийн 28.7% ТХГН-т, 12.3% лицензийн, голомт нутгийн 47.4% ТХГН-т, 8% лицензийн талбайд,

ЦЭН ТОГОРУУ


нийт 66261.28 км² нутагт байршихаас тархац нутгийн 24.1% ТХГН-т, 14.2% лицензийн, голомт нутгийн 23.6% ТХГН-т, 2% лицензийн талбайд хамрагдсан байна.

Манай орны хэмжээнд ойн туруутан, тал хээрийн туруутан, уулын туруутан болон жигүүртэн, тухайлбал цэн тогорууны хамгаалалд амьдрах орчин, тархац нутгийн давхцаа хамгийн өндөр, хамгааллын


холбогдлоороо чухал 8 нэр бүхий ТХГН түүний орчмын нутгуудыг өргөтгөх, коридор нутаг байгуулах дүгнэлт саналыг ажлын үр дүнд дэвшүүлэв.




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны алтайн хойлогны тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны аргаль хонины тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны тарваганы тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны цоохор ирвэсний тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны цагаан зээрийн тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны цэн тогорууны тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны молцог хандгайны тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны баданга хүдрийн тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны халиун бугын тархац, амьдрах орчин



Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны бор гөрөөсний тархац, амьдрах орчин




Судалгааны үр дүн: ОНТХГН ба Монгол орны зэрлэг гахайны тархац, амьдрах орчин




СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН:

Түлхүүр зүйл амьтдын тархац, амьдрах орчны давхцал ба УТХГН




СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН:

Түлхүүр зүйлүүдийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор зарим УТХГН-г өргөжүүлэх үндэслэл



СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН:

Түлхүүр зүйлүүдийн тус бүрээр амьдрах орчныг хамгаалах зорилт үндэслэл




“ГУЛЗАТ” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР


*Увс аймгийн Бөхмөрөн,
Сагил сумдын нутаг, улсын
хил орчмын 215,995 га
газарт ховор болон агнуурын
амьтдын нөөцийг хамгаалах,
зохистой ашиглах, нутгийн
иргэдэд түшиглэсэн ан
агнуурын менежментийг
хөгжүүлэх зорилгоор*

2008 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-ын 36 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Гулзат орон нутгийн хамгаалалттай газар нь Аргаль хонь (*Ovis ammon*)-ны цөм байршил нутаг, тархац нутаг төдийгүй хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*), монгол тарвага (*Marmota sibirica*), цоохор ирвэс (*Panthera unica*), халиун буга (*Cervus elaphus*), алтайн хойлог (*Tetrao ualtaicus*), алтайн сонгино (*Allium altaicum*) зэрэг ховор амьтан, ургамал тархсан байдгаараа онцлогтой.

Энэ газрын ховор амьтан, ургамалыг хамгаалах, тогтвортой ашиглах нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн загварыг бий болгох зорилгоор НҮБХХ, ДДБХС-гаас “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд Гулзат орон нутгийн хамгаалалттай газар (ОНХГ) байгуулагдан, нутгийн иргэдийн оролцоотой менежментийн бүтэц бий

болж, олон талын оролцоотой байгаль хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж ирсний дүнд Гулзат ОНХГ-т аргаль хонины тоо толгой 2003 онтой харьцуулахад 6 дахин өссөний зэрэгцээгээр тус газрын байгалийн нөөцийн ашиглалт (ялангуяа аргаль хонины спорт агнуур), менежментийн амжилт, сургамж нь энэ чиглэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндэслэл болж байгаа нь төслийн гол үр дүн юм.





ГУЛЗАТ ОНТХГН: ТУХАЙЛСАН ХӨХТӨН, ШУВУУНЫ ЗҮЙЛҮҮД

ХӨХТӨН

Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	Argali sheep
Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	Siberian ibex
Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	Goitered gazelle
Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	Wild boar
Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	Mongolian marmot
Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i>	Snow leopard

ШУВУУ

Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	Golden eagle
Цэвдгийн ахууна	<i>Lagopus mutus</i>	Rock ptarmigan
Зэрлэг гургуул	<i>Phasianus colchicus</i>	Common pheasant
Алтайн хойлог	<i>Tetrao urola</i>	Altai snowcock
Ойн шийхнүүхэй	<i>Anthus trivialis</i>	Tree pipit
Уулын цэгцгий	<i>Motacilla cinerea</i>	Grey wagtail





АРГАЛЬ ХОНЬ



ЛАТИН НЭР: *Ovis ammon.*, Linn
1758

АНГЛИ НЭР: Argali (Wild) sheep

ТАРХАЦ: Монгол оронд Монгол алтай, Говийн алтай тэдгээрийн салбар уулс, Хөвсгөл орчмын уулс, Хангайн гол нуруу, Зүүнгарын говь, Алтайн өмнөх говь, Өмнөговийн уулс, Хангайн зүүн, Хэнтийн өмнө зах хаялгын нам уулсаас урагш Төв халхын тал хээр, Дорноговийн нам уулс аараг толгодоор өргөн тархжээ. Ой, эгц хясаа ханан хадгүй задгайдуу уулсаар нутаглана. Нам уулс, аараг толгод, заримдаа элсэн манханд нутаглана. Цөөнөөр сүрэглэнэ. Өвөл нүүдэллэхдээ 40-50 аас 60-70 аар бөөгнөрнө. Зун өглөө орой шөнийн, өвөл өдрийн бэлчлэг хөдөлгөөнтэй. Өвслөг ургамлаар идэшлэнэ. Ууланд өлөн, сөөгийн мөчир найлзуур, говь цөлд бут сөөгийн мөчир, шаваг, элдэв үетэн бударгана, зээргэнэ, таана, хүмүүл иднэ. Ороо нийлэг IX-X сард болно. Хомь IV-V сард 1-2 хурга гаргана.

Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чоно, цоохор ирвэс, еврази шүлүүс, цармын болон тарваж бүргэдэд бариулж идүүлнэ. Гүйцэд тарга хүч аваагүй бол их цастай онцгой хүйтэн өвөл тэжээлгүйдэн турж өлбөрч үхдэг. Сэг зэмээр нь сэг идэшт элдэв амьтан тэжээллэнэ. Ургамал нөмрөг, хөрс бүрдэлд шууд дам өргөн оролцоо холбогдолтой. Байршил нь заримдаа бог малын бэлчээртэй давхцаж ус, идэш, тэжээл,

нутгаар хавчигдан шахагддаг. Мах арьсны уламжлалт чухал ан.

Гадаад шинж: Зүс нэн хувирамтгай, нутаг бүрт өөр өөр. Биеийн урт 110-190 см, сэрвээгээрх өндөр 65-125 см. Төрөл дотроо биеэр алтайн аргаль хонь хамгийн том. Угалзын хүзүү хэнхдэгийн үс өвөл уртавтар, гэхдээ зогдор шиг уртсахгүй. Өвлийн зүс цайвар буурал, хүрэвтэр буурал, бор.

ЯНГИР ЯМАА



ЛАТИН НЭР: *Capra sibirica.*, Pall 1776

АНГЛИ НЭР: Siberian ibex

ТАРХАЦ: Монгол оронд Хөвсгөл орчим, Хангайн өмнө, баруун хэсэг, Монгол алтай, Говийн алтай, Зүүнгар, Алтайн өмнөх говь, Өмнөговь, Дорноговь болон Төв халхын хээрийн нам уулсаар тархсан. Хадат уулсаар нутаглана. Хэдхэнээс хэдэн арван толгойгоор сүрэглэнэ. Далайн түвшнээс 1000-4000 м түүнээс дээш мөнх цасны хормой хүртэл нутагшина. Зун улам их өндөрт, өвөл цаснаас дайжиж нилээд доошлон идэшлэхээс гадна зудад цас үл тогтох бэрх хад сархиагтай газар хоргодон хадны өвс идэж зудаас үл айна. Зун өглөө оройн, өвөл өдрийн бэлчлэг хөдөлгөөнтэй. Зун уулын орой зоо, ар хажууд, өвөл уулын дундаас доош энгэрт бэлчиж байршлаа сэлгэнэ. Зүйл бүрийн өвс, үетэн, шаваг, сонгинолог сөөг ургамлаар идэшлэнэ. Ороо нийлэг XI-XII сард болно. Хээлээ 150-170 хоног тээнэ.



Амьдас нийцийн ач холбогдол: Цоохор ирвэс, саарал чоно, еврази шүлүүс, цармын болон тарваж бүргэдэд бариулж идүүлнэ. Онцгой их цастай хүйтэн өвөл тэжээлгүйдэн турж өлбөрч үхнэ. Сэг зэмээр нь сэг идэшт элдэв амьтан тэжээллэнэ. Ургамал нөмрөг хөрс бүрдэлд шууд дам өргөн оролцоо нөлөөтэй. Байршил нь заримдаа бог малын бэлчээртэй давхцаж ус тэжээл нутгаар хавчигдаж шахагддаг. Мах арьсны уламжлалт ан.

Гадаад шинж: Бие бахим, лагс, 115-165 см урт Сэрвээгээрээ 70-110 см өндөр. Жин 155 кг хүрнэ. Хөл

богино. Тэх арагш дээш чиглэн үзүүр нь доош эргэн дугуйрсан сэлэм хэлбэрийн 138 см хүрэх урт том, бараавтар өнгийн эвэртэй. Эмэгж 40 см хүртэл урт, жижиг, хөнгөн, хавтгайдуу эвэртэй. Сахал урт. Зуны зүс хүрэн бор, улаавтар бор. Хэвэл цайвар. Хэвэл их биеийн өнгө тодорхой зааггүй, нэг нэгэндээ аажим шингэж шилжсэн. Зоо нуруу дагуу нарийхан бараан судал бий. Тэхийн зүс насаар янз бүр болж хувирна. Тэхийн зоо нуруу хүзүү, урд хөл, өвдөг, гуя өвөл бараан, бараан загалтай бор, цайвар саарал. Эмэгж зун жигд хүрэн, бор, өвөл жигд бор саарал.



ХАР СҮҮЛТИЙ



ЛАТИН НЭР: *Gazella subgutturosa.*,
Guild 1780

АНГЛИ НЭР: Black-tailed or
Goitered gazelle

ТАРХАЦ: Монголд Зүүн гар, Алтайн өмнөх говь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Өмнөговь, Дундговь, Дорноговь, зүүн тийш бараг Онгон элс тултал, хойш бараг Хангай, Хэнтийн зах хаяа уулс дөхтөл тархмал. Хуурай хээр, говь цөлд нутаглана. Цөөн, олноор сүрэглэнэ. Намар өвөл хэдэн арав, зуугаар сүрэглэнэ. Өвслөг, сөөг ургамлаар идэшлэнэ. Зун шөнө өглөө оройн, өвөл өдрийн бэлчлэг хөдөлгөөнтэй. Оруу нийлэг XII-I сард болно. Сартагчин V-VI сард 1-2 янзага гаргана. Хатуу дагжуур хөрстэй бутлаг гашуун ургамал ба үет ургамал заг бударганатай говь цөлд нутаглана. Тэгш талд элбэг бэлчихийн хамт аараг, толгод, уулын бэлийн сархиа садаргаар тохиолдоно. Гантай жил ус бараадаж бэлчинэ.

Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чоно, еврази шүлүүс, цармын болон тарваж бүргэдэд идүүлнэ. Цас зудад нэрвүүлж үхэж үрэгддэг. Ус өвс ногоотой юмуу цас багатай дулаан нутагруу ойр зуур бэлчээр сэлгэн шилжинэ. Сэг зэмээр нь сэг идэшт элдэв амьтан тэжээллэнэ. Ургамал нөмрөг хөрс бүрдэлд шууд дам өргөн оролцоо нөлөөтэй. Байршил нь заримдаа бог малын бэлчээр, устай давхцаж хавчигдаж шахагддаг. Мах арьсны уламжлалт ан. Ахуй, экспортын чиглэлээр агнадаг байсан.

Гадаад шинж: Бие 97-118 см урт. Сэрвээгээрээ 61-77 см өндөр, сүүл 16-24 см урт. Орооны үед манхимын (сартагийн) төвөнх түнхийж томорно. Ооно, шаргачингаас биеэр яльгүй том. Дээш арагш яльгүй цалайж үзүүр нь хооорондоо ойртож дотогш яльгүй хумийсан олон цагираг бүхий 41 см хүртэл урт, шовх бараан эвэртэй. Шаргачин эвэргүй. Зоо нуруу, биеийн хажуу зун улаавтар бор, өвөл цайвар бор, бор саарал зүстэй. Хэвэл өөхийн тод цагаан өнгө их биеийнхээс эрс ялгарч зааграна. Хонгоны цагаан тан сүүлний угаас дээш хондлойруу хэтрээгүй.

МОНГОЛ ТАРВАГА

ЛАТИН НЭР: *Marmota sibirica.*,
Radde 1862

АНГЛИ НЭР: Siberian
(Mongolian marmot)

ТАРХАЦ: Монгол оронд 2 зүйл бий. Монгол тарвага Монгол алтайн зүүн хэсэг, Говийн алтай, Соёны нуруу, Байгал нуураас урагших, зүүнтээх нутаг, Монголын баруун, баруун өмнө, умар, төв болон бүх зүүн, нутагт тархмал. Уулын хээр, тал хээр, нугархаг, говирхог, хээрт нутаглана. Олон, цөөн, ганц амсартай олон салаалсан, нарийн бүтэцтэй урт гүн нүх малтаж орогноно. Өдөр, голдуу өглөө оройн идэшлэг үйл хөдөлгөөнтэй. Зүйл бүрийн өвслөг ногоон ургамлаар тэжээллэнэ. Өвөл Х-III сард ичээлнэ. Ичээ нүхний амсрыг дотроос нь шороогоор бөглөдөг. Тарч жилд нэг удаа хавар төллөж 9 хүртэл, голдуу 3-5 мөндөл төрүүлнэ. Хүйтэн тундрээс хээрийн бүс хүртэлх ойгүй задгай уул, талд нутаглана. Ууланд д.т 4500 м хүртэл тааралдана. Өвслөг ургамал ихтэй өндөр уулын энгэр бэл, голуудын хөндийд элбэг тохиолддог. Монголын төв ба баруун талын тарвага далайн түвшнээс дээш 1500-3000 метрийн өндөрт орших уулын хээр болон орой энгэр, бэлээр голчлон амьдардаг. Тарвага нүх ухаж бүлээрээ амьдардаг амьтан. Ухсан, нүхнийхээ



шороог амсар хавьд бөөгнөрүүлэн овоолж дош үүсгэдэг. Дошны өндөр нам нь газар бүр харилцан адилгүй байдаг ба тачир ургамалтай газрынх жижиг сахлаг ургамал тай хээрийн бүсийнх том байна. Тарваганы нүх ичээ, зусаал, муу нүх буюу түр хоргодох нүх гэж 3 янз бий. Нүхний урт ба гүн нь хөрсний бүтцээс шалтгаална.

Амьдас нийцийн ач холбогдол: Мах идэшт шувуу хөхтний тэжээл болно. Нүхэнд нь зарим шувуу жижиг хөхтөн, элдэв нугаламгүй амьтан түр юмуу байнга орогнож хоргодно. Хөрс бүрдэл, ургамал нөмрөгийн

нөмрөгийн хөгжилд асар өргөн эерэг нөлөө холбогдолтой. Аюулт халдварт тахал, бусад зарим өвчин үүсгэгчийг агуулагч дамжуулагч тараагч голомт болно. Монголд үслэг арьс, мах өөх тосны уламжлалт үндсэн түгээмэл ан.

Гадаад шинж: Бие 370-630 мм, сүүл богиновтор 90-160 мм урт. Жин 9.5 кг хүрнэ. Зоо нурууны сор үсний үзүүрийн бараавтар, хүрэвтэр өнгө мөн үсний уг, ноолуурын цайвар өнгөтэй найралдан боровтор, хөхөвтөр шаравтар саарал зүстэй. Толгойн орой бараан, хүрэн. Хацар шанаа толгойнхоо оройноос цайвар. Хэвэл шаргал.



ЦООХОР ИРВЭС

ЛАТИН НЭР: *Uncia uncia.*,
Schreber 1775

АНГЛИ НЭР: Snow leopard

ТАРХАЦ: Төв азийн Соён, Хангай, Алтай, Тэнгэр уул, Памир-Алай, Хималай, Төвдийн уулсаар тархмал. Монгол оронд Монгол алтай, Говийн алтай, тэдгээрийн салбар уулс, Өмнөговийн уулс, Хангайн хөвчин нуруу, Хөвсгөл орчмын зарим уулсаар тааралдана. Монголд зун уулын мөнх цасны зах хүртэл 1200-3000 м өндөрт тааралдана. Голдуу янгир ямаа, хааяа аргаль хонь барьж иднэ. Тарвага, туулай, огдой, хахилаг, хойлог, цагаан ятууг барьж иднэ. Уулын амьтан бөгөөд таг, царам, байц, хад, цохио, нураг, асга бүхий бэрх бартаатай газар байршина. Өвөл өндөр ууланд их нас унахад аргал, янгир, хойлог зэрэг идэшлэдэг амьтнаа бараадан дагаж уулын энгэр, бэлрүү уруудаж байрлана. Тархсан нутгийнхаа хаана ч ялгаагүй их цөөн сийрэг, ховор тохиолддог амьтан. Өвөл хаврын заагаар II-III сард 20 орчим хоног отлоно. Гинс V-VI сард хадны ангал, агуй, асганы хүнгэд 2-5 гүем төрүүлнэ. Гүем хөхөө 3 сар орчим хөхнө. Гинс жил өнжиж төллөнө. Бүрэнхий харанхуйн, заримдаа өдрийн үйл хөдөлгөөнтэй.

Амьдас нийцийн ач холбогдол: Уламжлалт үнэт үслэг ан. Монголд цоохор ирвэс агнахыг хуулиар хориглосон. Идэш тэжээл нь болдог том бага хөхтөн, зэрлэг тууртан, бусад амьтан ховордоход малд халдаж, мал аж ахуйтныг ноцтой хохироох явдал тохиолдоно. Байршиж буй нутгийнхаа анхаарал татагч, тодорхойлогч зүйл.

Гадаад шинж: Бие сунагар, 135 см, сүүл 90 см хүртэл урт. Сэрвээгээрээ 60 см өндөр. Жин 40 кг хүрнэ. Хөл богино, алга тавхайн ул өргөн том. Урт хурц нумал хумстай. Нүд том, хүүхэн хараа дугуй. Цайвар шаргал юмуу шаргалдуу дэвсгэр дээр 6-8 см хөндлөвчтэй дугуйвтар бараан толбо бүхий эрээн цоохор зүстэй. Хэвэл, хөлийн дотор тал цайвар, толбогүй. Толгойн орой, дух магнай шигүү жижиг бараан толботой.

ЗЭРЛЭГ ГУРГУУЛ

ЛАТИН НЭР: *Phasianus colchicus.*,
Linn 1758

АНГЛИ НЭР: Common pheasant

ТАРХАЦ: Манай орны баруун хязгаарт буй гургуул Баян-Өлгий, Ховдын шугуй, Хар ус нуур, Зэрэг сумын нутагт хэсэг хэсгээр ургасан хус, бургасан төгөл шугуйгаар мөн Увс аймгийн Бөхмөрөн гол, Ачит нуурын эрэг хавиар, зүүн талдаа Их хянганы салбар уулс, Буйр нуурын зэгс Гүү азарга, Халх, Шинэ, Эмнэгтийн голууд, Хүйтэн, Авдрантын булгийн зэгсэнд тархацтай болно. Элсэрхүү хөрстэй, бургас, зэгсэн төгөл, ургамал, усахар баялаг, цас бага ордог нутагт байдаг.



Идэш тэжээл: Дэгдээхийгээ зүйл бүрийн шавж, ургамлын навч цэцэг, үр жимсээр хооллоно. Гургуул тэжээлдээ царцаа, цох, шоргоолж, төөлүүр, аалз, чийгийн улаан хорхой, эмгэн хумс, оготны гөлчгий, гүрвэл, могой зүйл бүрийн зэрлэг ба тариалангийн ургамлын үр, нахиа, цэцэг, жимсгэнэ, үндэс зэргийг хэрэглэдэг байна. Гургуул бол бургас, модны хортон, билчээр сүйтгэгч элдэв шавж хорхой, хог ургамлын үрийг их хэмжээгээр идэж устгадагаараа хөхөө аж ахуйд үлэмжийн тус үзүүлдэг шувуу болно.

Гадаад шинж: Эрийн биеийн ерөнхий зүс улбардуу бараан хүрэн, хөндлөн жижиг хар толбо олонтой. Хушууны уг хоолой, хүзүү, дагз, нүдний доод хэсэг хар, гялалзсан ногоон туяатай. Хацар, завьж нүцгэн, улаан арьстай. Хүзүүнийхээ уганд цагаан бүслүүртэй. Хондлой цэнхэрдүү ногоон туяатай, саарал, сүүлний өд шаргалдуу бор хүрэн, хөндлөн хар судалтай. Цээж арай бараан, биеийн хажуу цайвардуу шаргал. Эм нь эрээсээ жижиг, бие бүхэлдээ шаргалдуу бор хүрэн, бараан-хүрэн хөндлөн судал, толбо ихтэй учир цоохор. Сүүл богино, хөндлөн хар бараан судалтай. Хушуу бор шаргал. Хөл бор-саарал.





АЛТАЙН ХОЙЛОГ

ЛАТИН НЭР: *Tetragallus altaicus*
Gebler., 1836

АНГЛИ НЭР: Altai snowcock

ТАРХАЦ: Говь-Алтайн уулсын Цамбагарав, Хархираа, Түргэн, Асгат, Хөх сэрх, Мөнхсарьдаг, Сутай, Хүрэнхайрхан, Жинстхайрхан, Хонгор хайрхан, Алаг хайрхан, Жаргалант хайрхан, Сагил болон Хангай, Ханхөхий, Хөвсгөлийн уулын ойт хээрийн бүслүүрийн д.т.д 2700-3000 м өндрийн ноён оргилын байц цохио, ханан хад, нураг асгатай ой модгүй тэгш, мөлгөр хяртай энгэр, хажуу, хунх, нугачаа, судаг, хярын зоонд байршина.

Идэш тэжээл: Үетэн, холтсонцэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн, буурцагтны овгийн ургамлаар голлон хооллоно. Мөн арвай, улаан буудай, вандуй, шар будаа, овъёос, багсармал тэжээл иднэ. Бүргэд, үлэг харцага, ирвэс, шилүүс, үнэг зэрэг махчин амьтад хороодог. Үүр, өндөг, дэгдээхийг хадны суусар, дорго сүйтгэнэ. Эмчилгээ сувилгаанд махыг хэрэглэх зорилгоор хулгайгаар агнаж тоо толгойг бууруулж байна.

Гадаад шинж: Бараан саарл зүстэй. Нуруу, сүүлний бүрхүүл өдүүд цагаан судалтай. Бүдүүн хүзүү, гүеэндээ хөндлөн хар жижиг толбуудтай. Хоолой, хэвэл цагаан. Биеийн хажуу, гуя хар өдтэй. Өдний үзүүр өргөн хар эмжээртэй. Хушуу бүдэг хар. Шилбэ, савар шаргалдуу туяа бүхий хүрэн бор хайрстай. Нүдний доор, ар талд тод шар, шаргал нүцгэн арьстай. Бие гүйцсэн эмийн шилбэ эвэрлэг шивүүртэй. Эр, эмээсээ биеэр том.

ЦАРМЫН БҮРГЭД

ЛАТИН НЭР: *Aquila chrysaetos L.*,
1758


АНГЛИ НЭР: Golden Eagle


ТАРХАЦ: Жаргалант хайрхан, Хангай, Хэнтийн район, Атас богд, Цагаан богд, Баруун хурай, Байтаг богд, Тахийн шар нуруудаар болон Хөвсгөлийн орчмын нутгаар тохиолдоно. Цармын бүргэд суурин амьдардаг шувуу. Байц хад, эгц цавчим чулуутай ой мод, тал хээр, говийн уулсаар амьдарна.



Идэш тэжээлийн хувьд туулай, амьтдын сэг, мэрэгчид, тарвага, хойлог гол хэсгийг бүрдүүлнэ. Ихэнхдээ туулай, огдой, зурам зэргээр хоолох бөгөөд зарим үед ишиг, хурга шүүрэх тохиолдол байдаг. Цармын бүргэдийг Баян-Өлгий аймагт үнэг, туулай гэх мэтийн жижиг амьтан агнахад ашигладаг. Зэрлэг ба тэжээвэр амьтдын үр төл ялангуяа хурга, ишиг шүүрдэг тул энэ талаараа хөдөө аж ахуйд хортой шувуунд тооцогдоно.

Гадаад шинж: Ерөнхий өнгө бараан хүрэн, хэвлий, гуя, сүүлний доод өд алтлаг зээрд туяатай. Дагзны хурц үзүүрт өдүүд, хүзүүний ар тал шаргал зээрд. Далавч хар хүрэн, саарал. Нүд бор хүрэн. Хушуу эвэрлэг цэнхэр, зэтэр, сарвуу шар, хумс хар. Шилбэ сарвуу хүртэл өдтэй. Эрийн далавч 600-645, эмийнх 635-725 мм.





Идэш тэжээл: Зуны улиралд виргини шувуун нударга, хурган засаа, сонгино, ортууз, гичгэнэ, зөжир өвсний үр навч, цэцэг иддэг. Өвөл гол төлөв 10-20 толгойгоор сүрэглэн тэжээл хайн хавь орчиндоо нүүдэллэн цас малтаж бургас бутны үр нахиа, жимсээр хооллоно.

Гадаад шинж: Өвөл эр, эм шувууд дун цагаан. Нүдний дээд хэсгээр нарийн жижиг улаан судалтай.

Цагаан ахуунаас ялгаатай нь хушуунаас нүд хүрсэн хөндлөн богино хар судалтай, зуны зүс арай саарал. Эм нь цагаан ахууны эмтэй төсөөтэй ч хушуу арай жижиг. Хушуу хар. Зун эрийн толгой, хоолой, цээж, нуруу бүхэлдээ саарал туяатай бор шаргал ба бараан, бор шаргал хагас саран толбуудтай учир цоохор. Хэвлий, сүүлний доод өд цагаан.

ЦЭВДЭГИЙН АХУУНА

ЛАТИН НЭР: *Lagopus mutus*
Montin., 1776

АНГЛИ НЭР: Rock Ptarmigan


ТАРХАЦ: Ойн дээд бүс, таг царамтай Хангай, Хөвсгөлийн уулс, Монгол Алтайн мөнх цаст оргилуудад тархсан. Өндөр уул, таг, цармаар амьдарна. Монгол Алтайд цэвдгийн ахууна цагаан ахуунаас дээхнүүр, чулуурхаг, чийглэг, усархуу хөрстэй тачирхан үетэн, зөжир өвс, сэрдэг алтайн холтсон цэцэг бүхий өндөр уулын таг нуруудад амьдарна.

УУЛЫН ЦЭГЦГИЙ

ЛАТИН НЭР: *Motacilla cinerea*
Tunstall., 1771

АНГЛИ НЭР: Grey wagtail

ТАРХАЦ: Хангай, Хэнтийн уулын бүс нутаг, ойт хээрийн район, Хөвсгөлийн тойрог, Монгол Алтай, Булган голын хөндий, Говь-Алтайд ховор, Их Богд, Гурвансайханд тохиолдоно. Бургас, харгана, торлог мэт модлог ургамалтай юмуу хад асгатай уулын гол горхи, булагийг бараадан байршдаг. Ойн дээд хязгаараас дээш гардаггүй.



Идэш тэжээл: Жижиг цох, шулуун далавчтан, аалз, ялаа, батгана, усны шавж, авгалдай голлоно.

Гадаад шинж: Нуруу бүслэхүйгээ хүртэл үнсэн саарал. Бүслэхүй, сүүлний дээд өд ногоовтор шар. Далавчны өд хар хүрэн, цагаан эмжээртэй. Дэвүүрүүд хүрэн.

Далавчны дээр цайвар тольттой. Сүүлний хоёр захын өд цагаан. Хөмсөг цагаан. Завьжнаас хүзүүний хоёр хажуугаар үргэлжилсэн сахал шиг цагаан зурвастай. Хоолой, эрүү, гүеэ хар. Хэвлийн хэсэг шар, суга цагаан саарал. Хушуу хар, хөл хүрэн.

“ХАВТГАР” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР


*Хэнтий аймгийн
Батширээт сум дахь
Хавтарын орон нутгийн
тусгай хамгаалалттай газар
Нь*

тус суманд нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент (НИТБНМ) болон нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутаг (НИХГН)-ийн загвар бий болгон хөгжүүлэх, тус хамгаалалттай газрын байгалийн нөөцийг тогтвортой зөв ашиглах, зэрлэг ан амьтны өсөж үржих таатай орчин нөхцлийг бүрдүүлснээр ан агнуурын менежментийг сайжруулж, аялал жуулчлал хөгжүүлэх замаар сумын нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн амьжиргаанд бодитой хувь нэмэр оруулах

зорилгоор Хэнтий аймгийн Батширээт сумын “Хавтгар” орчмын 1049,3 км² газрыг сумын ИТХ-ын 2003 оны 2-р сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ангиллаар хамгаалалтад авсан.

2013 оноос Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ-ийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлага дор “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ МОН13/303” төсөл хэрэгжиж байна.





ХАВТГАР ОНТХГН: ТУХАЙЛСАН ХӨХТӨН, ШУВУУНЫ ЗҮЙЛҮҮД

ХӨХТӨН

Халиун буга	<i>Cervus elaphus</i>	Red deer
Молцог хандгай	<i>Alces alces</i>	Moose
Баданга хүдэр	<i>Moschus moschiferus</i>	Musk deer
Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	Roe deer
Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	Wild boar
Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	Mongolian marmot

ШУВУУ

Үлэг харцага	<i>Accipiter gentilis</i>	Nothern goshawk
Хар хур	<i>Lyrurus tetrix</i>	Black grouse
Алаг тоншуур	<i>Dendrocopos major</i>	Great spotted woodpecker
Цэнхэр цанцаахай	<i>Cyanopica cyana</i>	Azure-winged magpie
Бидэрт самарчшаазгай	<i>Nucifraga caryocatactes</i>	Spotted nutcracker
Их хөхбүх	<i>Parus major</i>	Great tit

ХАЛИУН БУГА



ЛАТИН НЭР: *Cervus elaphus* Linn.,
1758

АНГЛИ НЭР: (European) Red deer

ТАРХАЦ: Монгол оронд Монгол алтай, Хангай, Хэнтий тэдгээрийн бэлийн болон салбар хаяа уулс, Хөвсгөл орчим, Их хянганы салбар уулсаар тархмал. Уулын шилмүүст ой, нам уулсын ойт хээр, голын хөндий татмын бут сөөгөн шугуй, хааяа ойгүй уул толгодоор нутаглана. Өвөл голдуу 7-15, түүнээс олноор сүрэглэнэ. Орооноос бусад үед дайр согоо тус тусдаа сүрэглэнэ. Ихэвчлэн өглөө оройн бэлчлэг хөдөлгөөнтэй. Зарим нутагт улирлаар ойр зуур бэлчээр сэлгэнэ. Зун өвслөг ургамал, мод бутны навч найлзуур өвөл өвслөг ургамал бут сөөгийн найлзуур, хаг хөвд иднэ. Ороо нийлэг IX, X сард болно. Дайр 2-3-аас 15-30 хүртэл согоо хурааж хээлтүүлнэ. Дайрын эвэр III сарын 10 орчмоос V сарын 20 хүртэл унана. Цусан эвэр III сарын 20-оос VIII сарын эцэс хүртэл ургаж дуусна. Анхны цусан эвэр 12-13 сартайгаасаа ургаж эхлэнэ.



Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чононд, хааяа хүрэн баавгайд бариулж идүүлнэ. Нялх илий нь еврази шүлүүс, нохой зээхэд бариулна. Сэг зэм үлдцээр нь сэг идэшт элдэв амьтан тэжээллэнэ. Ойн хөрс, ургамал нөмрөг ялангуяа модны нөхөн ургалтад ихээхэн нөлөө оролцоотой. Мах, арьс, Дорно, Өмнийн зах зээлийн эрэл хэрэгцээт эмийн түүхий эд, цусан эврийн уламжлалт ан. Дайрын хавар бүхэн хаядаг ясан эвэр нь экспортын үнэт түүхий эд. Халиун бугын аж ахуйд үржүүлэн цусан эвэр мах эмийн түүхий эд бүтээгдэхүүн авдаг. Эвэр олзворын анчин сонирхдог. Хууль бус агнуурт онцгой өртдөг зүйл.

Гадаад шинж: Монгол орны халиун бугын бие, эврийн хүнд, салааны тоо Монгол алтайгаас Хянганы салбар уулс чиглэлд аажим багасна. Зүс мөн чиглэлээр үл мэдэг өвөл цайвар, зун улаавтар болно. Бие том 185-240 см урт, сэрвээгээрээ 115-155 см өндөр. Сүүл богино, 20 см хүрнэ. Монгол орны буга том, Хэнтий, Хангайн бугын бие 193-247 см урт, сэрвээгээрх өндөр 124-165 см. Голдуу 6-7 салаалсан 1 м хүрэх урт, хосоор 5-10 кг хүнд эвэртэй. Зуны зүс жигд ухаа хүрэн. Өгзөг хонго хондлойн арын хэсгийг хамарсан том тод цайвар ягаавтар тантай. Өвөл дайрын хүзүү мөр өөхий бараавтар, бие цайвар саарал, согоо жигд цайвар бор саарал зүстэй.



МОЛЦОГ ХАНДГАЙ

ЛАТИН НЭР: *Alces alces* Linn., 1758

АНГЛИ НЭР: (European) Moose

ТАРХАЦ: Хөвсгөл орчим, Хэнтийд шивир молцог хандгай Хянганы салбар уулс, Халх голын савд дорнын молцог хандгай гэх хэлбэр бий. Монгол оронд Төв хэнтийн тайга, Хөвсгөл орчмын уулс, Умар хангайн Бүрэнгийн нурууны зүүн хойд хэсэг, Хянганы салбар уулс, Халх голын савд тархжээ. Хэнтий, Хөвсгөл, Умар хангайд уулын шилмүүст ойд, Хянганы салбар уулс, Халх голын савд голын татам, нуурын хаяаны бут сөөг зэгсэн шугуй, нам уулс толгодын дундах намагтай газар нутаглана. Хэнтийд д.т. 1100-2100 м өндөрт байршиж өвөл 1400 м-ээс дээш бараг гарахгүй. Өвөл тэжээлд нь бут сөөг, модны мөчир найлзуур зонхилно. Уул өөд их өндөрт гарахгүй ямагт ой ширэнгэ голын хөндий намаг нуур бүхий ширэнгэнд байршина. Тэжээлийн гол хэсэг нь аль ч улиралд мод, бутны мөчир навч нахиа, найлзуур холтос, залуу мод бут болно. Зуны улиралд намаг, усны шүүслэг үет ургамал иднэ. Зун мараанд ирж шороо долооно. Үүр, үдшийн бүрэнхийгээр идэж өдөр ширэнгэ дотор хэвтэн амрана. Хэнтий, Хянганы салбар уулсад VIII сарын сүүлчээр ороо нийлэг болно. V сарын эцсээс, VI сарын дунд өнгөртөл төллөнө. Голдуу 2 ихэр ходол төрүүлнэ.



Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чононд, хааяа хүрэн баавгайд бариулж идүүлнэ. Сэг зэм үлдцээр нь сэг идэшт элдэв амьтан тэжээллэнэ. Ургамал нөмрөг ойн нөхөн ургалтад шууд дам олон талын оролцоо нөлөөтэй. Мах арьсны уламжлалт ан.

Гадаад шинж: Монгол орны хандгай биеийн хэмжээгээр дунд зэрэг. Биеийн урт 285 см, сэрвээгээрх өндөр 230 см. Гавал ясны их урт 60 см хүрнэ.


Зүс бараан, бараан хүрэн. Хоншоор, хөл цайвар. Хэнтийн бие гүйцсэн мэнжийн эвэр, дундаа "алга" мэт том хавтантай, түүний урт 50-90 см, өргөн 17-22 см, талбай 610-800 ам дөрвөлжин см хүрнэ. Саравч буюу доод захын салаа үзүүртээ 2-3 салаална. Өрөөсөн эврийн салааны тоо 10 хүрнэ. Хянганы салбар уулс, Халх голын савын хандгайн эвэр арай жижиг салааны тоо цөөн, хавтан бага буюу бараг үгүй.

БАДАНГА ХҮДЭР

ЛАТИН НЭР: *Moschus moschiferus*
Linn., 1758

АНГЛИ НЭР: Musk deer

ТАРХАЦ: Монгол оронд нэлээд дэлгэр тархсан. Хэнтий, Хангайн уулархаг нутаг, Хөвсгөл орчмын уулс, Монгол алтайн баруун хойд хэсэгт тааралдана. Монголд уулын шилмүүст ойд д.т. 1700-2300 м өндөрт тааралдана. Уулын ар, хэц хажуугийн сүүдэрлэг чийгтэй унанги мод ихтэй, шигүү ойд нутаглана. Хэсэгхэн газар эзэгнэн ганц нэгээр суурин байрлана. Өглөө, үдэш шөнийн бэлчлэг хөдөлгөөнтэй. Хэнтийд баданга хүдрийн ороо нийлэг XII-I сард болно. Хэнтий, Хангайд гирэгчин VI-VII сард голдуу 1, хааяа 2 ихэр шовшоорой гаргана.



Амьдас нийцийн ач холбогдол: Еврази шүлүүс, нохой зээх, саарал чононд бариулж идүүлнэ. Сэг зэм үлдэцээр нь сэг идэшт элдэв амьтад тэжээллэнэ. Ой тайгын ургамал бүрхэц хөрс бүрдэлд өргөн эерэг оролцоо нөлөөтэй. Хүдрийг аж ахуйд үржүүлэн өсгөж заар авч ашигладаг.

Гадаад шинж: Хангайн баданга хүдрийн биеийн урт 80-93 см, сэрвээгээрх өндөр 59-70 см, жин 9.4-14.0 кг. Гирээ 8 см хүрэх урт соёотой гирэгчин соёогүй.

Ерөнхий зүс хүрэн, бараан хүрэн, бор. Зоо нуруу биеийн хажуугаар тодорхой хэлбэргүй жижигхэн бүдэг шаравтар толботой цоохор. Толгойн орой саарал. Нүдний дээд доод тал цайвар саарал. Төвөнхөөс өвчүүний ар аймхай мөгөөрс хүртэл хүзүү, хоолой, хэнхдэг өөхий дагуу тууш тод хар судалтай. Цочиж сандрахдаа шүгэлдэх исгэрэх мэт дуугарна. Чээж нам, бөгс хондлой өндөр галбир өвөрмөц, голдуу дэвхэрч тонголзон явах аяг бусад гөрөөснөөс содон ялгаатай.



БОР ГӨРӨӨС

ЛАТИН НЭР: *Capreolus pygargus*
Pall., 1773

АНГЛИ НЭР: (European) Roe deer

ТАРХАЦ: Монгол оронд Хэнтий, Хангай, Хөвсгөл орчмын уулс тэдгээрийн хоорондох бүх ойт нутаг, Монгол Алтайн баруун хэсэг, Хянганы хаяа уулс, Дорно монголын тал хээрийн нэлээд хэсэгт тархжээ. Ойт хээр, ойгүй задгай хээр, нуга, задгай газар мод тайрсан талбай бүхий том навчит ой, шилмүүст ой тайгад нутаглана. Хээр, хааяа говийн гол нуурын татам, хаяаны шугуй, ширэнгэд тааралдана. Ойт хээрийн өмнө захаар ойгүй хээрт ч үзэгдэнэ. Ой, ойгүй задгай хээр хосолсон нутагт хамгийн элбэг. Улз, Тэс, Халх, Хэрлэн зэрэг голын татам хөндий дагаж хээрт гүн нэвтэрнэ. Дорно монголын өндөр өтгөн өвс, сөөг бүхий ойгүй намхан уулс, толгодорхог задгай тал хээрт элбэг тохиолдоно. Өвөл хавар нуцгэн энгэр ойн чөлөөнд идэжлэнэ. Зун зүйл бүрийн өвслөг ургамал, мод бутны навчаар өвлийн улиралд мод, бутны найлзуур, нахиа зүйл бүрийн өвс иднэ. Заримдаа хаг хөвд, элдэв жимсгэнэ, модны холтос, шилмүүс ч иднэ. Ороо нийлэг VIII сарын сүүлийн хагаст болно. Зүр VI сард төллөнө. Голдуу 2 ихэр, хааяа нэг юмуу гурван янгадай гаргана. Гурын эвэр XI сарын сүүлчээс XII сард унана.

Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чоно, еврази шүлүүс, нохой зээхэд, Хангай, Алтайд хааяа ирвэсэнд бариулж идүүлнэ. Ой, ойн орчмын ургамал нөмрөг, хөрс бүрдэл, мод бут сөөгийн нөхөн ургалтад шууд дам оролцоо нөлөөтэй. Мах арьсны уламжлалт ан.

Гадаад шинж: Монгол орны бор гөрөөс зүйлийнхээ дотор биеэр дунд зэрэгт орно. Биеийн урт 110-132 см, сэрвээгээрээ 80-90 см өндөр, жин 30-40 кг. Зун тод улаавтар, улаан зээрд, өвөл боровтор эрээлжтэй бор саарал. Гурын эвэр 45 см хүртэл урт, дээгүүрээ цалгар, доод хэсгээр булдруулаг.

ЗЭРЛЭГ ГАХАЙ

ЛАТИН НЭР: *Sus scrofa* Linn., 1758

АНГЛИ НЭР: (European) Wild boar

ТАРХАЦ: Монгол оронд Их хянганы хаяа уулс, Хэнтий, Хангай, Хөвсгөл орчмын уулс, Монгол алтайн баруун хэсэг, Их нууруудын хотгор, Шаргын говь, Зүүн гарын говь, заримдаа Алтайн өмнөх говьд тааралдана. Монголд уулын шилмүүст ой, голын татам, нуурын хаяаны бут шагшуурган шугуй, хааяа ойгүй уулс, говийн баян бүрдийн бут сөөг дотор нутаглана. Зун чийгтэй намаглаг газар баймхай. Зун голдуу шөнийн, өвөл өглөө үдэш өдрийн бэлчлэг хөдөлгөөнтэй. Ихэвчлэн 5-15, заримдаа 20-30 хүртэл толгойгоор сүрэглэнэ. Бие гүйцсэн, хөгшин бодон голдуу ганцаар явна. Холимог идэштэн. Тэжээлд ургамлын үндэс, иш, хушийн самар, элдэв үр буурцаг жимсгэнэ зонхилно. Мэрэгч, чийгийн улаан хорхой, шавж авгалдай, зөөлөн биетэн, өндөг, элдэв амьтны сэг иднэ. ороо нийлэг XII-I сард болно. Монголын хойд ойт нутагт V сард, Их нууруудын хотгор; Зүүнгарын болон Алтайн өмнөх говьд III-IV сард төллөнө.



Амьдас нийцийн ач холбогдол: Саарал чононд байнга, хүрэн баавгайд хааяа бариулж идүүлнэ. Нялх торой, бага залуу нь еврази шүлүүс, нохой зээхэд бариулна. Хушны самар ургаагүй жил идэш тэжээл эрж ойр хол нүүж хэсэхдээ их цастай тэсгим хүйтэнд тэжээлгүйдэж турж ядран төл багаасаа ширвэгдэн үхэх, махчин амьтанд бариулах элбэг. Гахайн тахлаар үе үе хиарна. Хөрс малтаж сэндчин үндэслэг иш, булцуу, элдэв шавж хорхойгоор идэшлэхдээ хөрс бүрдэл ургамал

нөмрөг, мод бут сөөгийн нөхөн ургалтад олон талын өргөн оролцоо ихээхэн эерэг нөлөөтэй. Мах өөхний уламжлалт ан.

Гадаад шинж: Бие 125-175 см урт, сэрвээгээрээ 80-100 см өндөр. Сүүл 20-30 см урт. Зүс бараан, бараавтар хүрэн, хүрэвтэр, бараавтар саарал. Хоншоорын үзүүр, хөл чих бараан. Зуны зүс бараандуу. Завьжнаас чих хүртэл цайвар судалтай. Нялх торой хүрэвтэр саарал дэвсгэр өнгөн дээр тууш цайвар шаравтар судлуудтай эрээн.



ҮЛЭГ ХАРЦАГА

ЛАТИН НЭР: *Accipiter gentilis L.*,
1758

АНГЛИ НЭР: Nothern Goshawk

ТАРХАЦ: Хэнтий, Хангай, Хөвсгөл, Алтайн ой модтой хэсэг, Ховд голын хөндийд суурин амьдардаг. Монгол орны ой, голын хөндийн өндөр, шигүү модтой хэсгээр үүрлэж, өвөлжинө. Нүүдлийн үедээ тал хээр, говийн уулсаар тохиолдоно.

Идэш тэжээлийн зонхиох хэсгийг сүүн тэжээлтэн амьтад эзэлнэ. Түүнийг хэрэмч шувуу гэж нутгийг ардууд ярьдгийг үзвэл тэжээлийн нилээд хэсгийг хэрэм эзэлдэг байж болзошгүй. Үслэг мэрэгчдийг устгаж ангийн баялагт хор хүргэх талтай боловч манай оронд ховор учир түүний хор холбогдол туйлын бага.

Гадаад шинж: Бие гүйцсэн бодгалын нуруу саарал хүрэн хөх саарлаас хүрэн хүртэл олон янз.

Толгой нуруунаас хар, заримдаа цайвар хүрэн бөгөөд цагаан толботой. Цагаан хөмсөгтэй, дагз цагаан толботой буюу хөндлөн хүрэн судалтай. Дэвүүрүүд хүрэн боловч дотор тал цагаан судалтай. Сүүл хүрэн, хөндлөн бараан судалтай. Хэвлий цайвар, заримдаа цагаан бөгөөд хөндлөн нарийхан хүрэн судалтай. Сүүлний доод өд цагаан. Нүд шар, зэтэр ба хөл шар, хушуу хар хөх, хумс хар. эрийн далавч 300-345, эмийнх 326-388 мм.

ХАР ХҮР

ЛАТИН НЭР: *Lyrurus tetrix L., 1758*

АНГЛИ НЭР: Black grouse

ТАРХАЦ: Ойтой ихэнх нутаг, Монгол Алтайн Ёл голын ой, Хэрлэн, Сэлэнгэ, Эг, Орхон, Туул голын сав, Хянганы салбар уулс, Нөмрөг, Халх голын бургасан шугуй, хамгийн өмнөдөд Хөгнөхаан, Батхаан уулын холимог ойд тохиолдоно. Холимог ой, ойн цоорхой, голын хөндийд тохиолдоно. Ойн захын тарианд олноор цуглана.



Идэш тэжээлд хаврын улиралд яргуй цэцэг, хөвд, үетэн, зун шимтэглэйн навч, намгийн холтсонцэцэгийн навч, үетэн, шоргоолж, аалз байна. Намар бяцхан навчит ортуузны навч, тагийн тарнын навч, бэр цэцгийн навч, шоргоолж, хар цох, царцаа, өвөл хусны нахиа, нарийн мөчир байна. Тариалангийн талбайдээр хаягдсан татаар, саргагын үр, буудай идэхээс гадна хар хур овъёос, (хошуу будаа) тарьсан газар цуглардаг. Шивэр хөтүү, нургийн сойр мэт ургамлын гаралтай тэжээл хэрэглэгч

шувууд дэгдээхэй бойжуулах үестээ голчлон шавжаар хооллоно. Ойн болон хүн амьтанд хөнөөл учруулагч хортой шавж шимэгчдийг үлэмж ихээр устгана.

Гадаад шинж: Бүх биеийн өд хар ба цэнхэр, ногоон металл туяатай. Сүүлний доод өд цагаан. Эрийн залуур өдний хамгийн гадна талын 3 өд уртасч гадагш тахирлан эргэсэн. Эмийн нуруу хүрэн, зээрд өнгийн хөндлөн толботой. Хэвлий нилээд цайвар бөгөөд хөндлөн бараан судалтай. Сүүлний доод өд цагаан толботой. Далавч 220-263 мм урт.



АЛАГ ТОНШУУР

ЛАТИН НЭР: *Dendrocopos major* L., 1758

АНГЛИ НЭР: Black grouse

ТАРХАЦ: Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөл, Хянганы районд ердийн тохиолдох суурин, ойр зуур нутаг сэлгэдэг шувуу.

Гадаад шинж: Толгойн дээд тал, нуруу, сүүлний дээд өдүүд хар, эрийн дагз улаан, эмийнх хар. зулуугийнх ягаавтар. Хушууны уг шар. Хэвлий ягаавтар хүрэн туяатай, ерөнхий өнгө цагаан сүүлний доод өд улаан. Сүүл ба дэвүүрүүд хар, цагаан толботой. Далавч 119-150 мм урт.

Идэш тэжээлд ойн элдэв хортон шавж, тэдгээрийн авгалдай зонхилно. Хавар, зунд шоргоолж түүний хүүхэлдэй, хар цохоор хооллоно. Хэрэв мод цохонд их нэрвэгдсэн байвал түүнийг их хэмжээгээр идэж устгадаг. Модны шүүс хөөх үед түүнийг ихээр ууна. Өвлийн улиралд ургамлын үр иднэ. Нарс, гацуур, шинэсний үр, арцны үр, төрөл бүрийн жимс, жимсгэнэ иднэ. Боргоцойг идэхийн тулд хуурай холтос юмуу хожуулын хонхорт түүнээ тавиад тоншиж задалж иднэ.

Ойн элдэв хортон шавж, тэдгээрийн авгалдайг олноор нь устгадаг. Хортон олширч буй нутгийг илрүүлж өгөх болон тэдгээрийн тоо толгой, үржих нөхцөлийг хязгаарлаж зохицуулж байдаг. Модны холтосыг хуулах, эсвэл модлогийг ухаж цоолж нүхэлснээрээ хортон цаашдын хөгжлийг зогсоодог. Элдэв хортонд нэрвэгдэж буй модыг олж тоншино. Мөн хонгилд үүрлэж өндөглөдөг жижиг шувуудад үржих аятай нөхцөл бүрдүүлж өгдөг ашигтай шувуу.

ЦЭНХЭР ЦАНЦААХАЙ

ЛАТИН НЭР: *Cyanopica cyana* Pall., 1776

АНГЛИ НЭР: Azure-winged Magpie

ТАРХАЦ: Тайга, ой, ойт хээрийн болон голын хөндийн шилмүүст, холимог ойд үүрлэж байршина.



Идэш тэжээл: VI сарын сүүлчээр дэгдээхийнүүдээ 100% янз бүрийн шавж тэдгээрийн авгалдайгаар тэжээнэ. VII/15 наас хойш залуу ба бие гүйцсэн шувуудын тэжээлд шулуун далавчтан, цох, хагас хатуу далавчтан болон жимс зонхилно. Мөн үржлийн үедээ хаварчийг голлон идэш тэжээлдээ хэрглэнэ. Үржлийн сүүлийн үедээ ихэвчлэн бие гүйцсэн өрөөсгөл хүр эрвээхий, царцаа, олон төрлийн шавжаар хооллох боловч өндөглөх, өндөг дарах, ангаахай өсгөх үедээ өрөөсгөл хүр

эрвээхийн авгалдай ба хүүхэлдэйг гол тэжээл болгоно.

Гадаад шинж: Толгой хар, сэрвээ, нуруу, хондлой, сүүлний дээд өд бор саарал. Эрүү, хоолой, гүеэ цайвар. Хоолойноос цээж хүртэл бүдэг шаргалдуу бор саарал. Цээжний дээд хэсэг, хэвлий, сүүлний доод даруул, биеийн хажуу бор өнгөтэй цайвар саарал. Далавчны их, дунд бүрхүүл өд, дэвүүрийн гадаад өрөвлөг, сүүл нмоин хөх. Дотоод өрөвлөг бор саарал, сүүл урт. Хушуу, хөл хар.



БИДЭРТ САМАРЧШААЗГАЙ

ЛАТИН НЭР: *Nucifraga
caryocatactes L., 1758*

АНГЛИ НЭР: Spotted Nutcracker

ТАРХАЦ: Монгол орны ойн бүсүүдэд өргөн тархсан суурин шувуу бөгөөд говь, хээрт тохиолдоно. Энэ шувуу гол төлөв уулын дээд бүслүүрт хушин ойд байх боловч хааяа нарс шинэсэн ойд үзэгдэх ба үржлийн үедээ хушин ойгоос өөр хаа ч тохиолодохгүй. Үржлийн биш үедээ бидэрт самарчшаазгай ойт хээрт тааралдана. Тэжээл ховордсоноос ойгоос алслан нүүдэл хийнэ.



Идэш тэжээл: Бидэрт самарчшаазгайн тэжээлийн зонхилох хэсгийг зуны улиралд янз бүрийн шавж, жижиг мэрэгчид, шавж идэштэн эзлэх ба намрын цагт шилмүүсний үр ялангуяа хушны самар онцгой ач холбогдолтой. Бидэрт самарчшаазгай бол хуш шатсан буюу огт байхгүй газар хушны үрийг тарааж хушин ойн талбайн хил хязгаарыг тэлэх ашигтай шувуу.

Гадаад шинж: Дух, зулай, дагз, хондлой толбогүй, хар хүрэн. Нуруу, дал, биеийн доод хэсэг бүхэлдээ хар хүрэн, том зуувин цагаан толботой учир цоохор. Ялангуяа цээж, хэвлийн цагаан толбо цагаан судал мэт. Сүүлний доод даруул цайвар, голоороо цагаан шаргал бцөргөн тууш судалтай. Далавч, сүүл хар. Сүүлний үзүүр цагаан оройтой. Хушуу, хөл хар.


ИХ ХӨХБҮХ

ЛАТИН НЭР: *Parus major L., 1758*

АНГЛИ НЭР: Great Tit

ТАРХАЦ: Алтай, Хөвсгөлд ердийн, Хангай, Хэнтийн тайга, ой, ойт хээр, голын хөндийн ой, бургасан шугуй, суурингийн цэцэрлэгээр тархана.

NOT EVALUATED	DATA DEFICIENT	LEAST CONCERN	NEAR THREATENED	VULNERABLE	ENDANGERED	CRITICALLY ENDANGERED	EXTINCT IN THE WILD	EXTINCT
NE	DD	LC	N	V	E	CR	EW	EX



Идэш тэжээл: Ургамлын бясаа, бүүрэг, өрөөсгөл хүр эрвээхэй, навч идэгч цох, тэдгээрийн авгалдай зэрэг ойн хортон шавжууд олон байдаг. Өвлийн улиралд ургамлын үр иднэ. Ангаахайгаа аалз, зөөлөн жижиглэсэн шавжаар тэжээнэ. Нэг үүрийн хос хөх бух шувууд ангаахай тэжээх хугацаандаа 5000 гаруй удаа хоол зөөнө. Өдөрт хөхбухын нэг бүл 3600 төөлүүр устгана (Болд, Довчин, 1974).

Гадаад шинж: Эрийн зулай, дагз, хүзүүний хажуу, хоолой, цээж хар, хөх туяатай. Хоолойноос сүүлний доод өд хүртэл тууш хар судалтай. Завьж, хацар, чихний бүрхүүл өд цагаан, дагз дээр цайвардуу шаргал ногоон толботой. Нуруу, хэвлийн хойд хэсэг, биеийн хажуу хүхрийн шар өнгөтэй. залуур өд хүрэн, захын хочр өд гадаад өрөвлөг, үзүүртээ цагаан толботой. Эрийн хоолой, цээж, хэвлийн голоор үргэлжлэх тууш хар судал харьцангуй богино, зүс цайруу.

“ТҮМЭНХААН ШАЛЗ” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР

“Түмэн хаан-Шалз”-ын орон нутгийн хамгаалалттай газар нь газарзүйн байрлалын хувьд Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Норовлин сумын хилийн зааг орчмын нийт 347743 га газрыг хамарсан “Дун хаан-Шалз”, “Тосон хулстай”, “Түмэн хаан-Могойн шил” гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.

“Түмэн хаан-Шалз”-ын орон нутгийн хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт цагаан зээр, тарваганы нөөц, тархац нутаг, бэлчээрийг гэрээгээр хариуцан хамгаалах 15 байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг байгуулах ажлыг зохион байгуулав. Нөхөрлөлийн нийт гишүүн өрх 110, хариуцан хамгаалах талбайн хэмжээ 160806.6 га.


“Дун хаан-Шалз”-ын орон нутгийн хамгаалалттай газрыг Дорнод аймгийн Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 20 дугаар тогтоолоор Дагуурын ойт хээр, цагаан зээр, Монгол тарвага, нүүдлийн шувуудад чухал газрыг хамгаалах зорилгоор хамгаалалтад авсан. Хамгаалалтад авсан нутаг дэвсгэрийн хэмжээ 123000 га.

“Тосон хулстай” орон нутгийн хамгаалалттай газрыг Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 20 дугаар тогтоолоор Дагуурын ойт хээр, цагаан зээр, Монгол тарвага, нүүдлийн шувуудад чухал газрыг хамгаалах зорилгоор хамгаалалтад авсан. Хамгаалалтад авсан нутаг дэвсгэрийн хэмжээ 125691 га.

“Түмэн хаан-Могойн шил”-ийн орон нутгийн хамгаалалттай газрыг Хэнтий аймгийн Норовлин сумын иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 09 дугаар тогтоолоор Дагуурын ойт хээр, цагаан зээр, Монгол тарвага, нүүдлийн шувуудад чухал газрыг хамгаалах зорилгоор хамгаалалтад авсан. Хамгаалалтад авсан нутаг дэвсгэрийн хэмжээ 99052 га.

Газарзүйн байрлалын хувьд Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Норовлин сумын хилийн зааг орчмын нийт 347743 га газрыг хамарсан “Дун хаан-Шалз”, “Тосон хулстай”, “Түмэн хаан-Могойн шил” гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Судалгааны дүнгээс үзвэл Түмэнхаан шалз ОНТХГ-т (Batsaikhan et al, 2010; Gombobaatar et al, 2011; Clark et al, 2006) энэ бүс нутагт 6 багт хамаарах 35 зүйлийн сүүн тэжээлтэн, 11 багт хамаарах 139 зүйлийн шувуу тус тус амьдардаг ажээ. Олон улсын Улаан дансанд хошуу галуу, идлэг шонхор, зээрд шонхор, цэн тогоруу, хонин тоодог зэрэг шувууд “эмзэг”, мануул, наран бүднээ, нохой тас, морин цууцаль зэрэг амьтад “ховордож болзошгүй” гэсэн ангилалд тус тус оржээ. Бүс нутгийн Улаан дансанд монгол тарвага, халиун буга, цагаан зээр зэрэг амьтдыг “устаж болзошгүй”, хярс, шар үнэг, саарал чоно, мануул, хошуу галуу, хархираа тогоруу зэрэг амьтдыг “ховордож болзошгүй”, цэн тогоруу, идлэг шонхор, хонин тоодог, шар элэгт хөмрөг зэрэг амьтдыг “эмзэг” хэмээн үнэлжээ.



ТҮМЭНХААН-ШАЛЗ ОНТХГН:

ТУХАЙЛСАН ХӨХТӨН, ШУВУУНЫ ЗҮЙЛҮҮД

ХӨХТӨН

Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	Roe deer
Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	Mongolian gazelle
Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	Mongolian marmot
Саарал чоно	<i>Canis lupus</i>	Grey wolf
Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	Red fox

ШУВУУ

Хошуу галуу	<i>Anser cygnoides</i>	Swan goose
Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	Saker falcon
Цэн тогоруу	<i>Grus vipio</i>	White-naped crane
Өвөгт тогируу	<i>Anthropoides virgo</i>	Demoiselle crane
Шоорон эвэртболжмор	<i>Eremophila alpestris</i>	Horned lark

СААРАЛ ЧОНО

ЛАТИН НЭР: *Canis lupus Linn., 1758*

АНГЛИ НЭР: (European) Grey wolf

ТАРХАЦ: Монгол улсын бүх нутагт тархмал. Монголд тайга, ойт хээр, тал хээр, говь цөл зэрэг байгалийн бүх бүс, ууланд тагийн бүслүүр, мөнх цасны зах хүртэлх янз бүрийн газарт хааяагүй тархмал. Голдуу мал, зэрлэг тууртнаар идэшлэнэ. Зун тарвага, туулай заримдаа бусад мэрэгч, шувуу барьж иднэ. Тэжээл ховортойд шувууны өндөг, ангаахай, шавж, жимсгэнэ ургамал ч иддэг. Хөгшин өлөгчин XII-II сард, залуу нь арай хожуу хээлтэнэ. Өлөгчин 63-65 хоног хээл тээж IV-V сард, хөгшин нь 6-8, заримдаа түүнээс олон, залуу нь арай цөөн бэлтрэг гаргана. Хөхөө 5-6 долоо хоног хөхнө. Бэлтрэгээ сар болсноос хойш өлөгчин дутуу боловсорсон хоол буюу гулгидсаараа тэжээж махан хоолонд дасгана. Өлөгчин төрсөн даруйдаа бэлтрэгээ сахин үүрнээсээ холдохгүй.




Амьдас нийцийн ач холбогдол: Зэрлэг туруутан, тарвага зэрэг мэрэгчийн өвчтэй, сул доройг барьж, элдэв хүүр сэг идэж байгалийг ариутган цэвэрлэж, зэрлэг ан амьтны байгалийн шалгарал, тоо толгойн зохицуулга, бодис эргэлтэд эерэг нөлөөлдөг. Манай бараг бүх нутагт саарал чоно малд довтолж мал аж ахуйтныг их хохироодог. Говь цөлд ховордсон тууртан амьтныг идэж хорооно. Бие хамгаалах хоргодоц нуугдац сайтай, ус, мал, халиун буга, бор гөрөөс, цагаан зээр элбэгтэй ойт хээр, тайга, уулархаг нутаг, дорно хээр

талд илүү элбэг. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг, гоц ховордсон олон зүйл зэрлэг тууртантай манай оронд саарал чонон тоо толгойг байнга зохистойгоор зохицуулж ашиглах шаардлага гардаг. Уламжлалт ан.

Гадаад шинж: Биеийн урт 105-160 см, сүүл 35-50 см. Жин 40-65 кг. Хөл урт, чийрэг. Хялгасан үс урт ширүүн, ноолуур бүдүүвтэр өтгөн. Газар нутгийн байдлаар зүс янз бүр. Шаргал, улаавтар, хөхөвтөр, саарал. Зоо нуруу дагуу хар сор үстэй тул бараан харагдана.

NOT EVALUATED	DATA DEFICIENT	LEAST CONCERN	NEAR THREATENED	VULNERABLE	ENDANGERED	CRITICALLY ENDANGERED	EXTINCT IN THE WILD	EXTINCT
NE	DD	LC	NT	VU	EN	CR	EW	EX



ШАР ҮНЭГ

ЛАТИН НЭР: *Vulpes vulpes* Linn., 1758

АНГЛИ НЭР: (European) Red fox

ТАРХАЦ: Монгол орны бараг бүх нутагт өргөн тархмал. Монгол орны уулын тайга, ойт хээр, хээр, говь цөлийн бүс, ууланд мөнх цасны зах хүртэл нутаглана. Өөрөө нүх малтах ховор, голдуу тарвага, дорго, хярсны эзгүйрсэн нүх, хадны ангалд хоргодоно. Тодорхой нутаг эзэгнэн суурин амьдарна. Амьтны гаралтай тэжээл зонхилуулж ихэвчлэн жижиг мэрэгчээр идэшлэнэ. Монгол оронд зүйл бүрийн жижиг мэрэгч, ялангуяа оготно, үлийч, чичүүл, огдой үнэгний үндсэн идэш тэжээл болно. Зун шавж, гүрвэл, мэлхий, шувууны өндөг, ангаахай иднэ. Өглөө, үдэш, шөнийн үйл хөдөлгөөнтэй. Отлох II-IV сард зэгэр уралцах, хэмхэлдэх элбэг. Ганц нэгээр явна. Голдуу 4-6, хааяа цөөхөн, эсвэл 14 хүртэл гавар төрүүлж 40 гаруй хоног хөхүүлнэ. 15 хүртэл насалдаг.

Амьдас нийцийн ач холбогдол: Уламжлалт үнэт үслэг ан. Монголын тал хээр нутагт хэт олширсон үедээ бэлчээрийн өвс хоосолж мал аж ахуйг хохироодог цайвар үлийчийн тоог цөөрүүлж зохицуулдаг их ач холбогдолтой. Газарт өндөглөдөг шувуудын өндөг, ангаахай идэх, галзуу өвчний нян хадгалах, тараах зэрэг сөрөг холбогдол бий.

Гадаад шинж: Бие урт сунагар. Хөл харьцангуй богино. Сүүл урт багасгар. Хоншоор уртавтар, нарийхан. Чих соотон, шовх. Зүс улаан зээрд, улаан шаргал, шар, цайвар шаргал, заримдаа сэрвээгээрээ бараавтар, хүрэвтэр бэдэртэй. Өехий хэвэл, хэнхдэг цагаан. Чихний ар тал, урд хөлийн шилбэний урд тал бараан, баргар үстэй. Сүүлний торгон үзүүр цагаан. Хааяа цайвар, саарал, бараан, (меланизм) бодгаль тааралдана.

ЦАГААН ЗЭЭР

ЛАТИН НЭР: *Procapra gutturosa*
Pall., 1777

АНГЛИ НЭР: Mongolian gazelle

ТАРХАЦ: Урьд Монгол орны бүх хээр, говь цөл, уулын хээр, хойш ойт хээрлүү гүн нэвтэрч байв. Одоо Монгол оронд дэлхэц нь нэлээд багассан. Хээр талын бүсэнд нутаглана. Голын хөндий, задгай хээр дагаж хойшоо уулын хээр, ойт хээрлүү, уулсын шил, бэлийн хээрэрхүү тал дагаж урагш говь, цөлрүү лав нэвтэрнэ. Хялгана, хиаг, дэгнүүлт үетэн бүхий намхан уулс, толгод ухаа гүвээт хээрт илүү баймхай. Хэдхэнээс хэдэн арав, зуу, мянгаар сүрэглэнэ. Зун төллөх, хавар намар нүүдэллэх үедээ хэдэн арван мянга хүртэл толгойгоор цуглан хүрээлнэ. Хялгана, хиаг, таана мангир, шаваг зонхилсон өвслөг ургамлаар идэшлэнэ. Оруу нийлэг XII сарын сүүл, I сард болно. Ооно хорь гуч хүртэл тооны шаргачин хурааж хээлтүүлнэ. VI сарын сүүлч, VII сарын эхний хагаст голдуу 1, хааяа 2 ихэр янзага гаргана.



Амьдас нийцийн ач холбогдол: Зузаан цасан бүрхүүлтэй онцгой хүйтэн өвөл турж тэжээлгүйдэн өлбөрч олноороо хорогддог. Саарал чоно, цармын болон тарваж бүргэдэд идүүлнэ. Дорно тал хээрт цусан хордлого гэх өвчнөөр үе үе хяардаг. Аюулт халдварт шүлхий, мялзан, цэцэг, годронгоор өвчилж үхэж үрэгдэнэ. Эдгээр өвчнийг бэлчээр тэжээл ус сэг идэштний хавьтлаар гэрийн болон зэрлэг туруутанд дамжуулан халдаахад их оролцоотой. Сэг зэмээр нь

сэг идэшт шувуу хөхтөн элдэв амьтан тэжээллэнэ. Ургамал нөмрөг хөрс бүрдэлд олон талын шууд дам оролцоо эерэг нөлөөтэй. Мах арьсны уламжлалт үнэт ан.

Гадаад шинж: Бие 109-152 см урт. Сэрвээгээрх өндөр 66-90 см. Сүүл 8-13 см урт. Жин ооно 47 кг, шаргагчин 36 кг хүрнэ. Зуны зүс улаавтар шаргал, хэвэл цагаан, их бие хэвлийн өнгө тодорхой зааггүй. Сүүл цайвар. Тан шаргалдуу туяатай цагаан. Өвлийн зүс цайвар сарал, цайвар шаргал. Өвлийн үс урт өтгөн. Шаргагчин эвэргүй.



ХОШУУ ГАЛУУ

ЛАТИН НЭР: *Anser cygnoides L.*,
1758

АНГЛИ НЭР: Swan goose

ТАРХАЦ: Булган, Бөхмөрөн, Ховд, Завхан голуудын адаг, Нууруудын хөндийн Орог, Бөөнцагаан, Өгий, Тэрхийн цагаан, Тэлмэн, Ойгон нуур, Хараа, буурын гол, Онон, Улз, Хрэлэн, Халх голын саваар өндөглөн зусна.

Идэш тэжээл: Ус намаг, нуур голын нугаар бэлчээрлэн, замаг, хиаг, үетэн зэрэг өвслөг ургамлаар хооллоно. Тариалан эрхэлж буй газар хавар, намрын улиралд тарианы үр, нахиа, түрүүгээр хоолох явдал бий.

Гадаад шинж: Биеэр том. Нуруу хүрэн, хэвэл, сүүлний доод, дээд тал цагаан. Хажуугийн өд хөндлөн цайвар хүрэн судлуудтай. Хүзүү, шил тод хүрэн. Хушуу хар, толгойноосоо урт. Дух, дагз шилнийхээ зурвастай адил хүрэн, шанаа цайвар, хөл улаан шаргал.

ИДЛЭГ ШОНХОР

ЛАТИН НЭР: *Falco cherrug* Gray,
1834

АНГЛИ НЭР: Saker falcon

ТАРХАЦ: Идлэг шонхор Монголд өргөн тархацтай, суурин шувуу. Ойн бүс рүү гүн түрж орсон уулын хээр, хад цохиотой газрууд, хээржсэн цөл, говийн арсгар барсгар толгод, хад чулуутай, модгүй уулсаар өргөн тохиолдох зүйл.



Идэш тэжээл: Идэш тэжээлийн үндсэн хэсгийг үхэр огдой, туулай, ногтруу эзлэх боломжтой бөгөөд цайвар үлийч зонхилно. Идлэг шонхор жижиг мэрэгчид, зраим туулай хэлбэртэн болон бор шувууны багийн шувуудаар хооллоно. Мөн цайвар үлийч, зурам зэрэг мэрэгчид идэж устгадгаараа манай орны хувьд бэлчээрийн хортон мэрэгчдийн тоог цөөрүүлэх ашигтай шувуу.

Гадаад шинж: Нуруу хар хүрэн, заримдаа нилээд тод хөндлөн цайвар судалий. Тэр судал бүсэлхий, сүүлний дээд өдүүдэд байнга үзэгдэнэ. Толгой, нуруугаараа цайвар. Хэвлий цагаандуу, түүн дээр хөндлөн судлууд ба толбо бий. Залуу шувуудын нурууны өднүүд цайвар хул эмжээртэй. Хэвлийд бараан тууш зураастай. Эрийн далавч 343-380, эмийнх 375-429 мм. Тал хээр, ойт хээрт хад чулуутай нутгууд, цөөн өндөр модтой задгай газруудаар тархана.



ЦЭН ТОГОРУУ

ЛАТИН НЭР: *Grus vipio Pallas., 1811*

АНГЛИ НЭР: White-naped Crane

ТАРХАЦ: Гол, нуурын хөндийн зэгс шагшуурга, өндөр ургамалтай ус намгархаг газарт, нүүдлийн үедээ тариалангийн талбай, тал хээрт тохиолдоно.

Гадаад шинж: Дух, нүдний ар, чихний бүрхүүл өд, шанаа, доод эрүүний дээд хэсэг улаан нүцгэн арьстай. Толгойн орой шилэн хүзүү, хоолой, хүзүүний өмнөд хэсгийн бараг хагас хүртэл цагаан. Биеийн бусад хэсэг хөхвөр саарал. Далавчны бүрхүүл өд, гуравдугаар дэргийн өд цайвар учир холоос алаг харагдана. Дэвүүр ад хар. Залуу шувуу нь бие гүйцсэнтэй төсөөтэй ч толгой, хүзүүний хэсэг шаргалдуу бор хүрэн өнгөтэй.

Идэш тэжээл: Шавж хорхой зэрэг, монгол бах түүний шанганцар, их байснаас үзвэл энд амьтны гаралтай гарлтай идэш тэжээл зонхилно. Түймэр, усны төвшин хэт багасах, өндөглөх орчинд тайван байдлыг алдагдуулах зэрэг нь ховордлыг гол шалтгаан болж байна. Ус нуур дагаж амьдардаг 31 зүйл илтсэн хошуутан, 1 зүйл ахууна, 15 зүйл цахлай, 2 зүйл сэлүүр


хөлтөн, 5 зүйл шилбэтэн, 3 зүйл шунгуур, 4 зүйл түнжүүр, 6 зүйл тогоруу, 47 зүйл цууцал болон бусад багийн олон шувуу гол нуурын үзэсгэлэн төдийгүй, тэр орчны шумуул, дэлэнч, усны цох, соно, зөөлөн биет, үхсэн ба эмгэгтэй загасаар хооллон хортоныг хороож усыг бохирдлоос нэг талаар хамгаална.

ӨВӨГТ ТОГИРУУ

ЛАТИН НЭР: *Anthropoides virgo* L., 1758

АНГЛИ НЭР: Demoiselle crane

ТАРХАЦ: Нүүдлийн өндөглөдөг, ердийн тохиолдох зүйл. Хээр, ойт хээрийн бүсээр өргөн тархсан.



Идэш тэжээл: Шавж түүний авгалдай (царцаа, голио мэт), нялцгай биетэн, ихэвчлэн ургамлын үр, үндсээр хооллоно. Тариалангийн талбайгаар хаварт сүрэг сүргээрээ цуглардаг өвөгт тогоруу нь утсан өт, цох хорхойн авгалдай мэтийн тариалангийн хортон шавжийн тоо толгойг үлэмж хэмжээгээр хорогдуулна.

Гадаад шинж: Толгой, хүзүү хар, нүдний араас багц

цагаан өд доош унжсан. Биеийн бусад хэсэг үнсэн саарал. Бусад тогоруутай харьцуулбал бие жижиг. Толгойн орой саарал. Нүд улаан. Хүзүү дагаж цээж хүрсэн хар өдтэй. Тэр нь зогдор мэт харагдана. Гуравдугаар зэргийн дэвүүр урт, унжиж сүүл мэт харагдана. Хүзүүний доогуур түүнийг голлосон хар судалтайгаараа хархираа тогоруунаас ялгарна. Залуу шувууны биеийн зүс бүхэлдээ саарал ч нуруу, далавч, сүүлэнд бор шаргал толбо, өнгөртэй.



ШООРОН ЭВЭРТБОЛЖМОР

ЛАТИН НЭР: *Eremophila alpestris* L.,
1758

АНГЛИ НЭР: Horned Lark

ТАРХАЦ: Манай орны бүх нутгаар
түгээмэл тархсан, суурин шувуу.


Идэш тэжээл: Жижиг цох, шоргоолж, царцаа, шавжийн авгалдай, аалз зэрэг амьтад гарахаас гадна ургамлын үр нахиа зонхилно. Монгол болжмор, боролзой болжмор, жиргэмэл, тоодог зэрэг манай хээр талаар түгээмэл байдаг шувууд хортон шавжийг зохих хэмжээгээр устгана.



Гадаад шинж: Нуруу сааралдуу, бүдэг ягаан туяатай, заримдаа шар туяа илэрнэ. Өдний гол бараан боловч

тод толбо үүсгэхгүй. Далавч бараан-хүрэн, цайвар эмжээртэй. Сүүл хар, нарийн цагаан эмжээртэй. Дагзны хоёр хажууд багц урталтар өд байх нь эвэр шиг харагдана. Хоолой шаргал, эсвэл цагаан, хар хүрээтэй тэр нь завьж, хацар, хоолой, гүеэ дагаж байрлана. Дух шар, чихний бүрхүүл шаравтар, хэвлий цагаан, саарал туяатай. Сүүл бага зэрэг ухлаадастай. Далавчны урт 94-119 мм.





ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:









ГУЛЗАТ







ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:

ГУЛЗАТ






ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:





ГУЛЗАТ
ГУЛЗАТ
ГУЛЗАТ

ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал: ХАВТГАР









ХАВТГАР







ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:

ХАВТГАР ХАВТГАР ХАВТГАР ХАВТГАР




ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:







ХАВТГАР ХАВТГАР ХАВТГАР ХАВТГАР

ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал: ТҮМЭНХААН-ШАЛЗ







ТҮМЭНХААН-ШАЛЗ







ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:

ТҮМЭНХААН-ШАЛЗ ТҮМЭНХААН-ШАЛЗ ТҮМЭНХААН-ШАЛЗ




ОНТХГН, нөхөрлөлүүдийн хариуцсан нутгийн мониторинг талбай ба замлал:



ТҮМЭНХААН-ШАЛЗ ТҮМЭНХААН-ШАЛЗ

БОЯБ хамгаалал, түлхүүр зүйлүүд ба холбоос нутгийн тухай ойлголт

Манай орны хувьд "Холбоос нутаг"-ийн талаархи ойлголт нь шинэ тутамд нэвтэрч байгаа хэдий ч энэ чиглэлээр нилээдгүй судалгаа, шинжилгээний ажлууд тодорхой байгууллагуудын түвшинд хийгдэж эхэлсэн байна.




Түүнчлэн Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ээс "Connectivity conservation areas guideline" боловсруулан баталгаажуулахаар ажиллаж байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны хамтран хэрэгжүүлж буй "Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ (БНМБХГНС)" төслөөс санаачлан **"Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөн, нүүдэл, амьдрах орчны холбоос нутгийн хамгаалал, эрхзүйн орчны өнөөгийн байдал"** сэдэвт хэлэлцүүлгийг 2016 оны 4 сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо НҮБ-ийн байранд зохион байгуулсан.




Энэ хурлаар төслийн хүрээнд хийгдсэн суурь судалгаа болон ОНТХГН-уудын байршил нутгийг харгалзан үзээд манай орны хэмжээнд гурван холбоос нутгийг санал болгож дэвшүүлсэн нь газарзүй, байгаль орчин, биологийн олон янз байдал, тухайлбал тухайлсан зүйлүүдийн тархац, амьдрах орчны загварчлал болон давхацлыг харгалзан үзсэн юм.


Түлхүүр зүйлүүдийн тархац, амьдрах орчны давхацлын (Hot-Point analysis) дүн шинжилгээ ба ОНТХГН-холбоос нутгийн санал




УТХГН: Түлхүүр зүйлүүдийн тархац, амьдрах орчны давхацлын (Hot-Point analysis) дүн шинжилгээ ба ОНТХГН-холбоос нутгийн санал




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан аймаг, сумууд




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан аймаг, сумууд ба монгол орны өндөршил




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан экологийн мужууд




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан Байгалийн бүс бүслүүрүүд



ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан Монгол орны цагаан зээрийн тархац, төллөдөг нутгууд (тал хээрийн туруутны жишээгээр)




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан Монгол орны аргаль хонины тархац, амьдрах орчин (уулын туруутны жишээгээр)




ОНТХГН: Холбоос нутгийн саналд хамрагдсан

Монгол орны халиун бугын тархац, амьдрах орчин (ойн туруутны жишээгээр)



ХОЛБООС НУТГИЙН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

*Холбоос нутгийн тухай
үзэл баримтлалыг биологийн
шинжлэх ухаанд үндэслэн
дэвшүүлсэн байдаг. Энэ
үзэл баримтлал зөвхөн
газрын амьтан, ургамлыг
хамгаалахад чиглэгджээ.*



Биологийн зүйлд тохирох байгалийн холбоос нутаг нь тодорхой нэг газар нутгийн физик хэв шинжид нийцсэн экологийн үйл явц, алив зүйл, түүний бодгаль организмын үзүүлэх хариу үйлдэлд хамаарах үйл ажиллагааны бүрэлдхүүнийг агуулсан, тухайн газар нутагт оршдог амьдрах орчны орон зайн зохицолт, нийцэлт шинжид хамаарах бүтцийн бүрдлийг агуулдаг (Crooks & Sanjayan, 2006b).

Энэ ерөнхий тодорхойлолтыг цааш нь нарийвчлан холбоосны дараах дөрвөн хэлбэрийг судлаачид ялгажээ. Үүнд:

1. Холбоос газар нутаг Landscape connectivity

Алив нэг газар нутгийн хүрээнд илэрч буй ургамлан бүрхэвчийн хэв шинжийн холбогдох байдлыг хүний зүгээс харгалзан үзэх ойлголтыг холбоос газар нутаг хэмээн үздэг (Lindenmayer & Fischer, 2006).

2. Холбоос амьдрах орчин Habitat connectivity

Тодорхой нэг зүйл организм оршин амьдрахад таатай жижиг алаг цоог амьдрах орчин хоорондоо холбогдох байдлыг холбоос амьдрах орчин гэж нэрлэдэг (Lindenmayer & Fischer, 2006).

3. Экологийн холбоос Ecological connectivity

Экологийн холбоос гэдэг нь усны экологийн урсац, байгалийн сүйтгэлийн үйл явц, амьдсын идэш тэжээлийн харилцаа зэрэгт хамаарах бүхий л үйл явцыг багтаасан өргөн цар хүрээтэй экологийн үйл явцын өөр хоорондоо холбогдох байдлыг илэрхийлсэн ойлголт юм (Lindenmayer & Fischer, 2006; Soulй et al, 2006).

Холбоос нутгийн хамгааллын чухал холбогдол

Биологийн олон янз байдлыг хамгаалах үйлсэд өөр хоорондоо холбоотой хамгаалалтай газартай өргөн уудам байгалийн төрхөө хадгалсан холбоотой газар нутаг шаардлагатайг нийтээр хүлээн зөвшөөрөөд байна. Амьдрах орчин, алив зүйлийн амьдралд ирээдүйд гарах өөрчлөлтийн уршиг, үр дагаврыг 2009 онд гүйцэтгэсэн уур амьсгалын өөрчлөлтийг урьдчилан таамагласан загварын үр дүн хүний нөлөөнөөс улбаатай уур амьсгалын өөрчлөлт илүү мэдэгдэхүйц болж буйг нотолсны зэрэгцээ, холбоос нутгийн хамгааллын талаарх хүмүүсийн сонирхлыг илүү өдөөсөн үйл явдал болсон.

Судлаачид уудам орон зайн цар хүрээнд холбоос нутгийн хамгаалалтай газрын ач холбогдлыг: “өнөөдөр оршиж буй хамгаалалтай газрын сүлжээг улам сайжруулж, “тэсвэрлэх” чадварыг нэмэгдүүлснээр өөр хоорондоо холбоотой оршиж байгаа хамгаалалтай газар нь уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн туулахад, ялангуяа тэдгээрийн холбоос чухал үүрэгтэй” хэмээн тодорхойлжээ.

Ашигласан бүтээл

1. Адъяа Я. 2000. Монгол тарвага. Улаанбаатар. 199 х.
2. Банников А.Г. 1954. Млекопитающие Монгольской Народной Республики. Тр. Монг. Комис. Вып. 53. Изд-во АН СССР. Москва. 669 х.
3. Батсайхан Н., Р.Самъяа., С.Шар., С.Р.Б.Кинг. 2010. Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага. Zoological Society of London. 307 х.
4. Батсайхан Н. "Тусгай хамгаалалттай газар нутаг хоорондын болон зэрлэг амьтны нүүдэл, амьдрах орчны холбоос нутгийн хамгаалал, эрх зүйн орчны өнөөгийн байдал" сэдэвт хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн тайлан. НҮБ. Улаанбаатар. 2016. 28х.
5. Бианки В.Л. 1915. Материалы для авиафауны Монголии и восточного Тибета: Монголия и Кам. Тр. Экспедиции Рус. Геогр. Общества, совершенной в 1899-1901 гг. под руководством. П.К.Козлова. Т.2 Петербург.
6. Болд А. 1968. Хэнтийн уулархаг районы шувууд (Зүйлийн бүрэлдэхүүн ба тархац). Биологийн ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 3:4-25.
7. Болд А. 1970. Хэнтийн уулархаг районы шувуудын экологи, газарзүйн тархацын зарим асуудал. Монгол орны газар зүйн асуудал. Улаанбаатар. ШУА-ийн хэвлэл. 10:77-88.
8. Болд А. 1973. Монгол орны шувуу. Биологийн ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 7:139-166.
9. Болд А. 1977. Птицы Хэнтэйского горного района и их практическое значение. Автореф.дис.канд.биол.наук. Улан-Батор. 33 с.
10. Болд А. 1992. Төв Хэнтийн шувуудын тухай. Хан Хэнтийн дархан цаазат газар байгуулах асуудал. Зуунмод хот. х. 43-48.
11. Болд А. 2003. Ойн шувуудын тухай. Монгол орны ой хөвч ТОМ. IV. (Хэвлэгдээгүй бүтээл).
12. Болд А., Н.Довчин. 1974. Шувуудын амьдралаас. Шинжлэх ухаан амьдрал. №6 (175):62-67.
13. Болд А., С.Дуламцэрэн., Ц.Жамсран., Н.Мөнхбаяр., Н.Цэвээнмядаг. (III, IV, V бүлэг). 2001. CITES. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци ЛАВЛАХ. Улаанбаатар. х. 56-263.
14. Болд А., Ш.Болдбаатар, Н.Цэвээнмядаг. 2002. Монгол орны шувуудын зүйлийн бүрэлдүүний жагсаалт. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. Эмхэтгэл. 1:19-38.
15. Болд А., Н.Цэвээнмядаг, Ш.Болдбаатар, Г.Майнжаргал. 2007. Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь. (латин-монгол-орос-англи-герман-франц-унгар-хятад-япон-солонгос). Улсын нэр томъёоны бичиг №2(150). Улаанбаатар. 158 х.
16. Болдбаатар Ш. 1997. Улаанбаатар хот, түүний орчмын шувуудын экологи, практик ач холбогдол. Биологийн ухааны дэд докторын зэрэг горилсон диссертаци. Улаанбаатар. М.У. ШУА. БУХ. 214 х.
17. Болдбаатар Ш. 2005 а. Алтанхөхийн шувууны судалгаанаас. Монгол орны хоёр нутагтан мөлхөгчид. 2:44-54.
18. Болдбаатар Ш., Ш.Төгсбаяр. 2013. Монгол орны шувууны фото лавлах. Улаанбаатар. 441 х.
19. Гантормаа Ч., П.Цогтсайхан. Х.Тэрбиш., С.Гомбобаатар., С.Шар., Б.Оюунцэцэг. 2013. Гүн-Галуутайн амьтан, ургамлын хөтөч. Улаанбаатар. х. 63-112.
20. Гантулга Д. 2010. Цэнхэр шаазгайн (Cyanopica cyanus Pallas., 1776) үржлийн амжилт, бүлсэг зан төрх. Магистрын диплом. УБ. 42 х.
21. Гомбобаатар С. 2013. Монгол орны идлэг шонхор (Falco cherrug). Монгол улсын их сургууль. Монголын шувуу судлалын нийгэмлэг. Улаанбаатар хот. 246 х.
22. Даш Д. 2004 а. Ландшафт. Монгол улс. Газарзүйн атлас. Ер. ред. Д.Доржготов Улаанбаатар. х. 54-55.
23. Гомбобаатар С., Д.Сумъяа, О.Шагдарсүрэн, Ч.Ууганбаяр, Д.Эрдэмбилэг, Е.Потапов, Н.Фокс. 1999. Монгол орны идлэг шонхор (Falco cherrug)-ын

- идэш тэжээлийн судалгаа. МУИС, э/ш бичиг. 9 (146):156-173.
24. Гомбобаатар С., Ч.Ууганбаяр, Д.Сумъяа, О.Шагдарсүрэн, Е.Потапов, Н.Фокс. 2001. Үржлийн ба намаржиж, өвөлжиж буй идлэг шонхорын идэш тэжээлийн судалгаа. МУИС-ийн э/ш бичиг. 12 (172):89-95.
 25. Гомбобаатар С., П.Жаргалсайхан. 2011. Хурх-Хүйтэний хөндийн шувууд. Улаанбаатар. 98 х.
 26. Даш Д. 2004 б. Байгалийн бүс, бүслүүр. Монгол улс. Газарзүйн атлас. Ер. ред. Д.Доржготов. Улаанбаатар. х. 58-59.
 27. Дуламцэрэн С. 1970. Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 137 х.
 28. Дуламцэрэн С., Д.Цэнджав. 1989. БНМАУ-н амьтны аймаг, ХӨХТӨН АМЬТАН. Улаанбаатар. 1989. 159х.
 29. Дуламцэрэн С. 2003. Дэлэнтний ангилалзүй, ангилбарын монгол нэр томъёо. Улсын нэр томъёоны комиссын мэдээ. Улаанбаатар. 43 х.
 30. Дулмаа А., О.Шагдарсүрэн. (Ред). 1972. БНМАУ-ын агнуурын амьтад ба ан хамгаалал. Улаанбаатар. 246 х.
 31. Их ав. Сэтгүүл. 2009. Улаанбаатар.
 32. Кищинский А.А., Фомин В.Е, Болд А., Цэвээнмядаг Н. 1982. Птицы горного массива Мунх-Хайрхан /МНР/. В кн. Зоологические исследования в МНР. М. Наука. с. 62-81.
 33. Козлова Е.В. 1930. Птицы юго-западного Забайкалья, Северной Монголии и Центральной Гоби. Л. Изд-во АН СССР, 356 с.
 34. Козлова Е.В. 1975. Птицы зональных степей и пустынь Центральной Азии. Л. Наука. 250 с. (Тр. Зоол. Ин-та АН СССР, т. 59).
 35. Козлова-Пушкарева Е.В. 1933. Птицы и промысловые млекопитающие восточно Кэнтэя. Л. Изд-во АН СССР. Тр. Монгол. Комис. АН СССР, вып. 10. 49 с.
 36. Майнжаргал Г. 2001. Сэлэнгийн хөндийн хар хурын (*Lyrurus tetrix* Linnaeus, 1758) биологийн зарим судалгаа. Биологийн хүрээлэн эрдэм шинжилгээний бүтээл. Улаанбаатар. 23:135-142.
 37. Майнжаргал Г. 2006. Хээр талд өндөглөдөг шувууд. Биологийн хүрээлэн, э/ш бүтээл. 26:120-123.
 38. Майнжаргал Г. 2014. Монгол орны богшигын овгийн шувуудын (*Alaudidae*) биологи, экологи, хамгаалал. Биологийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилж бичсэн бүтээл. УБ. 160 х.
 39. Намнандорж О. 1976. БНМАУ-ын дархан цаазтай амьтан. Улаанбаатар. 189 х.
 40. Пржевальский Н.М. 1876. Монголия и страны Тангутов. Трехлетнее путешествие в Восточной нагорной Азии. Том. II. Санктпетербург.
 41. Ричард Б.Примак., Д.Батболд., Р.Самъяа., Н.Батсайхан. 2003. Байгаль хамгааллын биологи. Улаанбаатар. 422 х.
 42. Самъяа Р., М.Мюленберг. 2006. Монгол орны байгаль хамгаалал. Улаанбаатар. 325 х.
 43. Степанян Л.С. 1978. Состав и распределение птиц фауны СССР. Воробьиные Passeriformes. М. Наука. 271 с.
 44. Степанян Л.С. 1990. Конспект орнитологической фауны СССР. М. Наука. 726 с.
 45. Степанян Л.С. 2003. Конспект орнитологической фауны России и сопредельных территорий. М. ИКЦ. Академкнига. 806 с.
 46. Сушкин П.П. 1938. Птицы советского Алтая и прилежащих частей северо-западной Монголии. М-Л. Изд АН СССР. т.2. 434 с.
 47. Тарасов П.П. 1960. Материалы по фауны птиц Юго-Восточной части Монгольского Алтая и прилежащей Гоби. Биологический сборник Восточно-Сибирский отд. Географического об-ва СССР. Противучумной Ин-та Сибири и Дальнего Востока. Иркутск. с. 158-178.
 48. Тугаринов А.Я. 1932. Птицы Восточной Монголии по наблюдением экспедиции 1928 года. Л. Изд-во АН СССР. 46 с.
 49. Фомин В.Е., А.Болд. 1991. Каталог птиц Монгольской Народной Республики. Москва. Изд-во. Наука. 125 с.
 50. Цэвээнмядаг Н., А.Болд., Ш.Болдбаатар., Г.Майнжаргал. 2005.

- “Хэнтийн уулархаг мужийн шувуу” Лавлах бичиг. Улаанбаатар. 129 х.
51. Шагдарсүрэн О. 1964. Хищные птицы центральной и южной частей Монголии и их практическое значение. Автореф. дисс. канд. биол. наук. М. 17 с.
 52. Шагдарсүрэн О., Сосорбарам Ж. 1968. Баруун монголд зохиогдсон амьтан судлалын экспедици. Биологийн ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 2:153-166.
 53. Шагдарсүрэн О. 1983. Монгол орны махчин шувуу. Улаанбаатар.
 54. Шийрэвдамба Ц. (Ер.ред). 2013. Монгол улсын улаан ном. Хоёрдугаар хэвлэл. Admon print. 535 х.
 55. Энхбилэг Д. (Ред). 2005. Байгаль хамгаалагчийн гарын авлага. Улаанбаатар. х. 96.
 56. BirdLife International and NatureServe (2012) Bird species distribution maps of the world.
 57. Dickinson E.C. (Editor). 2003. The Howard and Moore Complete Checklist of the birds of the World. 3rd Edition. Christopher Helm. London. 544 pp.
 58. Emma L, Clark and Munkhbat Javzansuren (compilers) S.Dulamtsuren, J.E.M.Baillie, N.Batsaikhan, R.Samiya and M.Stubbe (editors). 2006. Mongolian Red List of Mammals. Zoological Society of London, Regents Park, London. 159 p.
 59. Flint K. 1984. (ED). Impressionists in England: the critical reception. Routledge.
 60. Gombobaatar S., E.M.Monks (compilers) R.Seidler, D.Sumiya, N.Tseveenmyadag, S.Bayarkhuu, J.E.M.Baillie, Sh.Boldbaatar, Ch.Uuganbayar (editors). 2011. Mongolian Red List of Birds. Regional Red List Series Vol. &. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolia Ornithological Society (in English and Mongolian). ADMON Printing, Ulaanbaatar. 1036 p.
 61. Kleinstauber G., M.Succow. 1978. Zur Avifauna der Nordmongolie (westliche Chentei-Auslaufer und Vorland). Mitt. Zool. Mus. Berlin. 1978.Bd.54, Suppl. s.2-34.
 62. Mainjargal G. 2009 a. Breeding biology and its effected factors of some species of Alaudidae family. Современные проблемы орнитологии Сибири и Центральной Азии. Улан-Уде. 80-85.
 63. Mauersberger G.1980. Okofaunistische und biologische Beitrage zur Avifauna Mongolica. 2. Gruiformes bis Passeriformes. Ibid. 1980. Bd. 56. Suppl. s. 77-164.

Зургийн эх сурвалж

ХӨХТӨН

1. Аргаль хонь WWF Mongolia, Rich Reading, Б.Отгонбаяр/FB, www.nomadicjournyes.com
2. Янгир ямаа Rentsen Reno/FB;
3. Хар сүүлтий Ц.Пүрэвсүрэн, Валерий Малеев,
4. Молцог хандгай Key west Trvale Tours, www.Patroquerphoto.com, www.Omgihheartanimals.com
5. Халиун буга Bayar Balgantseren, Mongolia Birding and Wildlife Photography Tours, Smithsonian-www.mnh.si.edu,
6. Баданга хүдэр Goodrich-WCS Russia, Н.Батсайхан/FB, www.footage.framepool.com, www.worldwildlife.org
7. Бор гөрөөс www.animalsfoto.com, www.elelur.com, www.nzmc.org
8. Зэрлэг гахай Валерий Малеев, Petras Malukas, Jonathan C. Slaght, Petras Malukas
9. Монгол тарвага Валерий Малеев,
10. Цоохор ирвэс WWF, www.gandex.ru; www.7-themes.com;
11. Саарал чоно Wikiwand.com, www.motherearthnews.com
12. Шар үнэг www.WordPress.com, Getty Images, www.theattoohut.com
13. Цагаан зээр Marcel Huijser Photography, Ш.Болдбаатар, Manaljav Altanchimeg/FB,

ШУВУУ

14. Алтайн хойлог Purevsuren Tsolmonjav, www.Wildlifemongolia.com, Х.Түмэндэлгэр
15. Цармын бүргэд Manuel G.S, Keyword Suggestion, www.juzaphoto.com, www.Pbase.com
16. Үлэг харцага www.LuontoPortii.com, www.Pininterest.com, www.wallpapers13.com, www.igoterra.com,

17. Хар хур www.federbestimmung.de, www.JuzaPhoto.com, www.pernatidruzi.org.ua
18. Цэвдгийн ахууна www.GBIF.org, www.commonswikimedia.org, www.tunturususi.com, www.tgreybirds.com
19. Зэрлэг гургуул www.PBase.com, On the Wing Photography, www.helgeschulz.de
20. Цэнхэр цанцаахай forum fur Naturfotografen-byBlauelster, alaspatasyplatas.blogspot.com, naturfotografen-forum.de-Patric Donini
21. Алаг тоншуур www.BioLib.com, Mike Lane-s Ramblings-WordPress.com, www.avibirds.com
22. Бидэрт самарч шаазгай Forum fur Naturfotografen, HBW Alive
23. Ойн шийхнүүхэй Forum fur Naturfotografen, HBW Alive
24. Их хөх бух pescadordeaves.blogspot.com, Chapim real-Youtube, JMrocer-Deviant-Art
25. Уулын цэгцгий www.reddishvale.moonfruit.com, www.commonswikimedia.org, www.Pbase.com
26. Хошуу галуу birds korea-Robin Newlin, Warren Photographic, Wildlife in Suburban Garden-Typepad
27. Идлэг шонхор www.PBase.com, www.commonswikimedia.org, www.sakertour.com, www.Bio-Foto.com
28. Цэн тогоруу Tum Eco Tour, Saijo-Ehime Wikimedia, Birding Beijing
29. Өвөгт тогируу C.Түвшинтөгс, www.fwf.punjab.gov.pk, www.es.treknature.com,
30. Шоорон эвэрт болжмор www.tgreybirds.com, Ozden Saglam Kulaji Toygar, www.Birdzilla.com
31. Боролзой богширго www.Mapio.net

Энэхүү гарын авлага, материалд оруулсан хөхтөн, шувууны зургуудийг тухайн зүйл амьтны харьцуулах онцлог шинж чанаруудыг тодорхой гаргаж үзүүлэх, ялган таниулах зорилгоор [Google.com/images](https://www.google.com/images) сайтаас чанар, үзүүлэлтийг сонгон татаж авсан болно.

Учир нь орон нутгийн иргэд, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн гишүүд, малчдад хялбар таниулах, БОЯБ-н конвенцийн үзэл баримтлалын дагуу тухайн амьдарч буй нутгийнхаа БОЯБ тэдгээрийг бүртгэн таних, судлах ажилд дадлагжуулах, сургах ажлын хүрээнд зөвхөн байгаль, хүрээлэн буй орчин, биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу сургалт, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх зорилгоор ашиглаж байгаа болно.

Олон нийтийн мэдээллийн хайлтын системд тавигдсан фото зургийг дээрх зорилгоор авч ашиглах үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд фото зураг бүрийн эх сурвалжийг гарын авлага боловсруулсан баг нотолгоо болгож тухайн зургийн файлын нэр болгон хадгалж авсан болохыг тэмдэглэж байна.

Хэрэв та өөрийн зургийн эх сурвалжийн талаар санал хүсэлт байвал denkhbileg@gmail.com хаягаар хандаж болно.